



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ II ТӨСЛИЙН ЭЦСИЙН ҮНЭЛГЭЭ

Судалгааны тайлан

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захиалгаар Мэргэжлийн социологчдын холбооноос боловсруулав.

5 дугаар сарын 2, 2023

ТАЛАРХАЛ

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захиалгаар Мэргэжлийн социологчдын холбоо нь Тогтвортой хөгжлийн боловсрол II төслийн Эцсийн үнэлгээг 2023 оны 1 дүгээр сараас 4 дүгээр сарын хооронд хийж гүйцэтгэв. Үнэлгээний ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай материал, мэдээллээр хангаж чиглүүлсэн ТХБ II төслийн Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагч А. Энхтогтох болон орон нутагт төсөл хэрэгжүүлэгч БОМСТ-ийн хамт олонд талархал илэрхийлье.

Түүнчлэн, төслийн талаарх өөрсдийн туршлага болон санал бодлоо хуваалцсан хүндэт ТЗЗҮБ, ТЗЗОНБ-ийн гишүүд судалгаанд хамрагдсан 36 сургуулийн удирдлага, менежер, багш, сурагч нар, эцэг эхчүүдэд гүнээ талархснаа илэрхийлж байна.

Үнэлгээний багийн гишүүд:

Б.Батзориг, Мэргэжлийн Социологичдын Холбоо
Г.Долгорсүрэн, Мэргэжлийн Социологичдын Холбооны үр нөлөөний үнэлгээний зөвлөх
А.Очбадрал, Дата аналит
Б. Энхжаргал, Талбарын судлаач
Б.Баттуяа, Талбарын судлаач
Д.Баярцолмон, Талбарын судлаач
Б.Олдох-Эрдэнэ, Талбарын судлаач

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

БОМСТ	Байгаль орчны мэдээлэл сургалтын төв (ТББ)
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БЕГ	Боловсролын ерөнхий газар
БСҮХ	Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн
БҮТ	Боловсролын үнэлгээний төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МУБИС	Монгол Улсын Боловсролын Их Сургууль
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НТБҮТ	Насан туршийн боловсролын үндэсний төв
ТЗЗҮБ	Техникийн зөвлөх зохицуулах үндэсний баг
ТЗЗОНБ	Техникийн зөвлөх зохицуулах орон нутгийн баг
ТББ	Төрийн бус байгууллага
ТХ	Тогтвортой хөгжил
ТХБ	Тогтвортой хөгжлийн боловсрол
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилтууд
СБААХ	Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага
ЦУНБХТ	Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв
ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг

АГУУЛГА

Талархал	2
Товчилсон үгсийн жагсаалт	3
Агуулга	4
Хүснэгт, зураг, ишлэлийн жагсаалт	6
Хураангуй	8
Үнэлгээний гол үр дүн, дүгнэлтүүд.....	8
Үндэслэл	13
I. Судалгааны зорилго, хүрээ	14
II. Судалгааны арга зүй	14
2.1. Эцсийн үнэлгээний дизайн	14
2.2. Мэдээлэл цуглуулалтын арга зүй, хэрэглэгдэхүүний хүрээ.....	14
2.3. Түүврийн дизайн, аргачлал	15
IV. Үр дүн.....	19
Түүвэр судалгаанд хамрагдсан бүлгүүдийн хүн ам зүйн үзүүлэлтүүд.....	19
4.1. Төслийн хэрэгжилтийн үр дүнтэй байдал.....	21
4.1.1. Төслийн логик хүрээнд тусгагдсан үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт	21
4.1.2. Төслийн микро, мезо болон макро түвшинд гарсан өөрчлөлтүүд.....	25
4.2. Төслийн ач холбогдолтой байдал	31
4.2.1. Сургуулиуд хэрэгжсэн төслүүд ТХ-ийн агуулгыг багтаасан байдал.....	31
4.2.2. Төслийн ач холбогдолтой байдалд гурван түвшний оролцогч талуудын зүгээс өгсөн үнэлгээний үр дүн	35
4.3. Төслийн үр ашигтай байдал	37
4.4. Төслийн тогтвортой байдал	40
4.4.1. Микро түвшний тогтвортой байдал	40
4.4.2. Төслийн мезо түвшний тогтвортой байдал	41
4.4.3. Төслийн макро түвшний тогтвортой байдал	42
4.5. Төслийн нийцтэй байдал	43
4.6. Төслийн үр нөлөөтэй байдал	45
4. Дүгнэлт.....	48
5. Санал, зөвлөмж	51
7. хавсралт.....	52
Хавсралт 1. Асуумж судалгааны үр дүн.....	52

А. Сурагчдаас асуумжаар авсан судалгааны үр дүн	52
Б. Багш нараас асуумжаар авсан судалгааны үр дүн	68
В. Эцэг эхчүүдээс асуумжаар авсан судалгааны үр дүн.....	83
Хавсралт 2. Аймгуудад тулгамдаж буй нийгэм, эдийн засаг, байгаль орчны асуудлууд.....	95
Хавсралт 3. Төслийн логик хүрээнд тавьсан шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт	98

ХҮСНЭГТ, ЗУРАГ, ИШЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Судалгааны мэдээлэл цуглуулалтын аргууд.....	15
Хүснэгт 2. Макро, мезо, микро түвшний оролцогч талууд	15
Хүснэгт 3. Төслийн зорилтот сургууль болон хяналтын сургууль	16
Хүснэгт 4. Тоон судалгааны түүврийн тоо хэмжээ.....	16
Хүснэгт 5. Судалгааны түүврийн хэмжээ	16
Хүснэгт 6. Чанарын судалгаанд хамруулах оролцогч талууд.....	17
Хүснэгт 7. Сургуулиудаас цугларсан статистик мэдээллийн жагсаалт.....	18
Хүснэгт 8. Судалгаанд хамрагдсан сурагчид, хүйс болон суралцдаг түвшнээр	19
Хүснэгт 9. Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүд, насны бүлэг, хүйс, боловсролын түвшингээр	19
Хүснэгт 10. Судалгаанд хамрагдсан багш нар, мэргэжлийн зэрэг, ажилсан туршлага болон боловсролын зэргээр	20
Хүснэгт 11. ТХБ II төслийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт.....	21
Хүснэгт 12. Микро түвшний оролцогч талуудын мэдлэг, ойлголтод гарсан өөрчлөлтүүд.....	28
Хүснэгт 13. Мезо түвшинд гарсан өөрчлөлтүүд	29
Хүснэгт 14. Макро түвшний суурь үзүүлэлтэд гарсан өөрчлөлт.....	29
Хүснэгт 15. Микро болон мезо түвшинд хэрэгжсэн төсөл, үйл ажиллагаанууд	31
Хүснэгт 16. Төслийн ач холбогдолтой байдал, сурагчдын үнэлгээгээр	35
Хүснэгт 17. Төслийн ач холбогдолтой байдал, багш нарын үнэлгээгээр.....	35
Хүснэгт 18. Төслийн төлөвлөсөн болон босгосон хөрөнгө оруулалт	37
Хүснэгт 20. Төслийн тогтвортой байдал, сурагчдын үнэлгээгээр	40
Хүснэгт 21. Төслийн тогтвортой байдал, багш нарын үнэлгээгээр	41
Хүснэгт 22. Төслийн логик хүрээнд тусгагдсан үр нөлөөний шалгуур үзүүлэлт ба биелэлт	45
Хүснэгт 23. Төслийн үр нөлөөтэй байдалд багш нарын өгсөн үнэлгээ	46
Хүснэгт 24. ТХ-ийн үзэл баримтлалыг түгээсэн туршлага, МУБИС-д түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаанд оролцсон хүний тоо, давхардаагүй тоогоор.....	47
Зураг 1. Эцсийн үнэлгээний дизайн.....	14
Зураг 3. Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага ба микро, мезо, макро түвшний оролцогч талуудын оролцоо, хамтын ажиллагааны зураглал.....	26
Зураг 4. Жижиг төслүүдийн чиглэл, агуулга, ТХ-ийн гурван тулгуур баганаар	31
Зураг 5. МУЗГ-ийн оруулсан хувь нэмэр, мөнгөн дүнгээр болон бодит мөнгөн бус дүнгээр, 2020-2022 он.....	37
Зураг 6. Төсвийн гүйцэтгэл, үр дүнгийн зорилтоор	38
Зураг 7. Төсвийн зарцуулалт, оноор	38
Зураг 8. БОМСТ-ийн менежментийн хүрээнд бий болсон хөрөнгө оруулалтууд, хувь нэмэр оруулагч талуудаар	38

Ишлэл 1. Эцэг эхчүүдийн мэдлэг ойлголт, дадалд гарсан өөрчлөлт	27
Ишлэл 2. Багш нар, суралцагчдын ТХ-ийн санаачлагыг дэмжиж ажилласан туршлага	27
Ишлэл 3. Сурагч нарын дадал зуршилд гарсан өөрчлөлт	27
Ишлэл 4. Төслийн хүрээнд орон нутагт хэрэгжсэн хамтын ажиллагааны туршлага.....	28
Ишлэл 5. Төслийн ач холбогдолтой байдлын талаарх макро түвшний оролцогч талын дүгнэлт	36
Ишлэл 6. Сурагчид ТХБ-ын үзэл баримтлалыг амьдралдаа дадал болгож, бусдад нөлөөлсөн туршлагаас	40
Ишлэл 7. ТХБ-ын тогтвортой байдалд багш нарын өгч буй үнэлгээ	41
Ишлэл 9. Төслийн хүрээнд орон нутагт бий болсон үр нөлөө	46
Ишлэл 8. Төслийн үр нөлөөний шалгуур үзүүлэлтийн биелэлтэд ТЗЗҮБ-ийн гишүүний өгсөн үнэлгээ	46

ХУРААНГУЙ

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захиалгаар Мэргэжлийн социологчдын холбоо нь Тогтвортой хөгжлийн боловсрол II төслийн Эцсийн үнэлгээг 2023 оны 1 дүгээр сараас 4 дүгээр сарын хооронд зохион байгуулав.

Эцсийн үнэлгээний зорилго нь төслөөс төлөвлөж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хүрээнд төслийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт болоод төслийн хэрэгжилтийн нийц, үр өгөөж, үр нөлөөг тодорхойлоход чиглэсэн байв.

Үнэлгээний хүрээнд 6 аймаг, Улаанбаатар хотын 4 дүүргээс сонгогдсон төслийн зорилтот (30) болон хяналтын (6) сургуулийн 1,709 сурагч, 546 багш, 1,178 эцэг эхээс асуумжийн аргаар мэдээлэл цуглуулсан ба ТЗЗҮБ ба ТЗЗОНБ-ийн гишүүд болон сургуулийн удирдлагатай нийт 30 ганцаарчилсан ярилцлагыг зохион байгуулав. Мөн эцэг эх, сурагчидтай 20 бүлгийн ярилцлагыг хийж, баримт бичгийн шинжилгээ хийсэн. Өөрөөр хэлбэл судалгаанд чанарын болон тоон мэдээлэл цуглуулалтын арга ашигласан ба үнэлгээнд Олон улсын эдийн засаг, хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын үнэлгээний шалгуур үзүүлэлтийг ашиглав.

Үнэлгээний гол үр дүн, дүгнэлтүүд

Төслийн үр дүнтэй байдал

ТХБ II төслийн гурван үр дүнгийн шалгуур үзүүлэлтэд хамаарах нийт 19 зорилт тавьсан ба 110%-ийн гүйцэтгэлтэйгээр амжилттай хүрсэн байна. Тодруулбал, Үр дүн 1. Шалгуур үзүүлэлт болох Сурагч, багш, сургагч багш, сургуулийн удирдлага, орон нутгийн удирдлагын ТХБ-ын талаарх ойлголт мэдлэг нэмэгдэнэ гэсэн зорилт 111%-иар биелж, Үр дүн 2-ын Шалгуур үзүүлэлт болох Сургалтын хэрэглэгдэхүүн нэмэгдэнэ (хөтөлбөр, агуулга, арга зүй, үнэлгээний хуудас) (99%), Үр дүн 3-ын Шалгуур үзүүлэлт болох ТХБ-ыг нэвтрүүлэх зорилтын хүрээнд үндэсний болон орон нутгийн түвшинд өгсөн бодлогын зөвлөмж боловсруулсан байна (104%) -иар тус тус амжилттай биелсэн байна. Үүнээс гадна Суурь судалгааны үзүүлэлт болон Эцсийн үнэлгээний үзүүлэлтийг харьцуулахад төслийн үр шим хүртэгчдийн мэдлэг, ойлголтод мэдэгдэхүйц эерэг өөрчлөлт гарсан байна.

Микро түвшний суурь үзүүлэлтүүдэд гарсан өөрчлөлтүүд

Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Эцсийн үнэлгээний үр дүн
I. Микро түвшний нөхцөл байдал		
Суурь үзүүлэлт 1.1 Тогтвортой хөгжлийн боловсролын талаар сайн мэднэ гэж хариулсан зорилтот сургуулийн сурагчдын хувь	10.8	30.2%
Суурь үзүүлэлт 1.2 Тогтвортой хөгжлийн боловсролын талаар сайн мэднэ гэж хариулсан хяналтын сургуулийн сурагчдын хувь	14.7	30.2%
Суурь үзүүлэлт 1.3 Тогтвортой хөгжлийн боловсролын талаар сайн мэднэ гэж хариулсан зорилтот сургуулийн эцэг эхчүүдийн хувь	26.7	39.3
Суурь үзүүлэлт 1.4 Тогтвортой хөгжлийн боловсролын талаар сайн мэднэ гэж хариулсан хяналтын сургуулийн эцэг эхчүүдийн хувь	19.0	12.6
Суурь үзүүлэлт 2.1 Орон нутагт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх санал гаргасан зорилтот сургуулийн ЕБС-ийн багш нарын хувь	21.9	12.2
Суурь үзүүлэлт 2.2 Орон нутагт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх санал гаргасан хяналтын сургуулийн ЕБС-ийн багш нарын хувь	19.7	6.5

Суурь үзүүлэлт 2.3 Орон нутагт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх санал гаргасан зорилтот сургуулийн ЕБС-ийн эцэг эхчүүдийн хувь	13.2	11.7
Суурь үзүүлэлт 3.1 Орон нутагт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх санал гаргасан хяналтын сургуулийн ЕБС-ийн багш нарын хувь	15.4	8.2
Суурь үзүүлэлт 3.2 Орон нутагт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх санал гаргасан зорилтот сургуулийн сурагч нарын хувь	14.4	22.5
Суурь үзүүлэлт 3.3 Орон нутагт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх санал гаргасан хяналтын сургуулийн сурагч нарын хувь	12.8	21.5
Суурь үзүүлэлт 4.1 Төслийн зорилтот ЕБС-ийн сурагчдын мэдлэг ойлголт, чадвар хандлага мэдэгдэхүйц өөрчлөгдсөн гэж үзсэн хариулсан сурагчдын хувь	37.2	42.6%

Мезо түвшний суурь үзүүлэлтүүдэд гарсан өөрчлөлтүүд

Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Эцсийн үнэлгээний үр дүн
I. Мезо түвшний үйл ажиллагааны нөхцөл байдал		
Суурь үзүүлэлт 5.1 ТХБ II төслийн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үйл ажиллагаа нь сайн хэрэгждэг зорилтот сургуулийн хувь	66.1	87.9%
Суурь үзүүлэлт 6.1 ТХБ II төслийн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үйл ажиллагаа нь сайн хэрэгждэг сургуулийн байгууллагын эзлэх хувь	64.3	100%

Макро түвшний суурь үзүүлэлтүүдэд гарсан өөрчлөлтүүд

	Суурь түвшин	Эцсийн үнэлгээний үр дүн
I. Макро түвшний үйл ажиллагааны нөхцөл байдал		
Суурь үзүүлэлт 7.1 ТХБ II төслийн ТЗЗҮБ-ийн үйл ажиллагааны хэрэгжилтийн өөрийн үнэлгээний хувь	84.6	100%

Төслийн ач холбогдолтой байдал

Төслийн хүрээнд хэрэгжсэн үйл ажиллагаанууд Суурь судалгаа болон Эцсийн үнэлгээгээр орон нутагт хамгийн их тулгамдаж буй асуудлууд хэмээн нэрлэгдсэн асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн байгаа нь төсөл ач холбогдолтой байсныг илтгэж байна. Төслийн хэрэгжих хугацаанд төслийн зорилтот сургуулиуд дээр нийт 130 үндсэн болон дэд төслийг хэрэгжсэн ба сургуулиуд тухайн орон нутгийн цаг уурын байдал, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулсан төслүүдийн санаачилсан байв. Жишээлбэл, Хэнтий аймгийн цөлжилт ихтэй бүс нутгийн Тэмүүжин цогцолбор сургууль сургуулийн хашаагаа зүлэгжүүлэх зорилготой төсөл хэрэгжүүлэх зорилт тавьсан байна. Мөн эцэг эхчүүдийн хүүхдүүдэд тавих хараа, хяналт муугаас өсвөр насны хүүхдүүд ялангуяа үе тэнгийнхний дээрэлхэлтэд өртөх, шилжилтийн насны сэтгэл зүйн асуудлуудаас гарч чадахгүй байх, хорт зуршилд автах, гэмт хэрэгт өртөх зэрэг эрсдэлүүд үүсч байгааг онцолж байсан юм. Үүнийг сургуулиуд дээр бэлтгэгдсэн сэтгэл зүйчид ажиллаж эхэлснээр шийдвэрлэх боломж бүрджээ.

Төслийн үр ашигтай байдал

Төсөл хэрэгжсэн хугацаанд МУЗГ болон БСҮХ-ээс 69,3 сая төгрөгийг бодит мөнгөн дүнгээр оруулахаар төлөвлөсөн бол төслийн хүрээнд оролцогч **талууд 976,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг босгож** нийт 1,046.1 сая төгрөгийн гүйцэтгэлийг хийсэн байна. Харин бодит бус мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх хувь нэмэр 152.2 сая төгрөг байхаар төлөвлөгдсөн бол нийт **1,005.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг босгож** нийт 1,157.8 сая төгрөгийн гүйцэтгэл хийсэн байна. Эдгээрээс харвал төсөл маш өндөр үр ашигтай ажиллажээ. Мөн Төслийг хэрэгжүүлэгч БОМСТ нь ТХБ II төслийн хүрээнд

орон нутгийн хувь нэмрийг 800 сая төгрөгөөр төлөвлөж байсан бол түүнийг 3 дахин нугалсан буюу 2.4 тэрбум болтол хөрөнгө оруулалтыг босгоход өөрсдийн хувь нэмрээ оруулжээ. Төслийн үр ашигтай байдлыг зорилтот орон нутгуудад бий болсон томоохон бүтээн байгуулалтаас харах боломжтой. Тэдгээрийн нэг нь Хөвсгөл аймгийн Дэлгэрмөрөн сургууль Хөдөлмөр зусланг барьсан ба төслийнхөө хүрээнд БШУЯ болон төгсөгчдийн хандиваар дотоод болон гадаад орчны тохижилтыг хийсэн байна.

Төслийн тогтвортой байдал

Төслийн тогтвортой байдлыг төслийн хүрээнд одоогийн гарсан үр дүн төслийн хэрэгжиж дууссны дараа урт хугацаанд хадгалагдах боломжтой эсэхийг харвал микро түвшинд нөхцөл харьцангуй сайн бүрджээ. Учир нь төслийн үзэл санаа сургуулийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө, сургалтын хөтөлбөр агуулга болон багш нарын ажлын тодорхойлолтод орж өгснөөрөө төслийн тогтвортой байдал хангагдах нөхцлийг бүрдүүлжээ. Түүнээс гадна сурагч, багш нар, эцэг эхчүүдийн мэдлэг, ойлголт, хандлагад гарсан эерэг үр дүнгүүд нь төслийн үр дүн хадгалагдахад хувь нэмэр оруулахаар нь тодорхой байна.

Харин мезо түвшний багийн оролцогч талууд байнга солигддоос шалтгаалж төслийн тогтвортой байдлыг хангахад шаардлагатай итгэл үнэмшил, оролцоо болон санхүүгийн хөшүүрэг зэрэг урьтач нөхцөл хангагдахгүй байна. Түүнчлэн ТЗЗОНБ-ийн гишүүд нь төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлснээрээ ямар нэгэн нэмэлт урамшуулал авдаггүй байдал нь тэдний оролцоо сул байх нэг шалтгаан болж байна. Тиймээс төсөл дууссны дараа төслийн багийн гишүүд энэхүү төслийн үзэл баримтлалыг үргэлжлүүлэхийн тулд идэвх, санаачлага гаргана гэдэг нь эргэлзээтэй.

Төслийн тогтвортой байдал нь макро түвшний оролцогч талуудын хамтын ажиллагаанаас шууд хамааралтай гэдэг утгаараа төсөл дуусч одоогийн ТЗЗҮБ татан буугдснаар төслийн хүрээнд хэрэгжиж байсан үйл ажиллагаа суларч, шинэ санал санаачлага гарахгүй байх эрсдэлтэй байна. Макро түвшний тогтвортой байдлыг бий болгоход төслийн хүрээнд бий болсон бүтцийг идэвхитэй хангах хууль эрх зүй, бодлогын түвшний дэмжлэг, орчинг бий болгох шаардлага харагдаж байна. ТЗЗҮБ-ийн албан ёсны бүтэц байснаараа оролцогч байгууллагууд тогтмол чадавхи бэхжүүлэх үйл ажиллагаануудад (сургалт, туршлага судлах тойрон аялалд) хамрагдаж үйл ажиллагаагаа илүү уялдаа холбоотой, үр дүнтэй төлөвлөж хэрэгжүүлэх давуу талтай болохыг төслийн хүрээнд харьцангуй богино хугацаанд гарсан үр дүнгүүд харуулсан. Үүнд, төслийн орон нутагт хэрэгжүүлэхээр сонгогдон ажилласан БОМСТ болон БСҮХ-ийн хажууд байгуулагдсан төсөл хэрэгжүүлэх нэгжийн үүрэг, оролцоо чухал байсныг онцлох нь зүйтэй.

Төслийн үр нийцтэй байдал

Төслийн нийцтэй байдлыг төслийн зорилго, зорилтууд МУ-д хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дараах бодлого, хөтөлбөрийн зорилтуудтай хэр уялдаж, тэдгээрт хэрхэн хувь нэмрээ оруулсныг тойм байдлаар харуулав. Дараах жасгаалтаас харуулсанчлан ТХБ II төсөл нь МУ-ын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын зорилго, зарчим болон МУ-ын дунд болон урт хугацааны бодлогын баримт бичгийн зорилтуудтай уялдсан үйл ажиллагааг хэрэгжүүлжээ. Тэдгээр дурдвал;

Тогтвортой хөгжлийн зорилт 2030

- Зорилт 4.а Хүүхэд, хөгжлийн бэрхшээл, жендерийн мэдрэмжтэй боловсролын байгууллагыг бэхжүүлэн сайжруулж, хүн бүрийг аюулгүй, хүртээмжтэй, үр дүнтэй суралцах орчноор хангах
- Зорилт 4.7 2030 он гэхэд тогтвортой хөгжлийн мэдлэг, тогтвортой амьдралын хэв маяг, хүний эрх, жендерийн тэгш байдал, энх тайван болон хүч үл хэрэглэх соёлыг төлөвшүүлэх, дэлхийн иргэн байх, соёлын олон янз байдал болон тогтвортой хөгжилд соёлын оруулж буй хувь нэмрийг ойлгуулах мэдүүлэх замаар тогтвортой хөгжлийг хөхүүлэх дэмжихэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг бүх суралцагчдад олгох;

Алсын хараа 2050

- Зорилго 2.1. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ,
- Зорилго 8. Үндэсний соёлоо дээдэлсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцад нэгдсэн, өрсөлдөх чадвартай, харьцангуй тэнцвэртэйгээр бүс, орон нутгийг хөгжүүлнэ.

Боловсролын тухай хууль

- 4.1. Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхитай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино.

Бага, суурь, бүрэн дунд боловсролын тухай хууль

- 6.1.2. Бүрэн дунд боловсролын агуулга нь байгаль, нийгэм, хүмүүнлэг, математик, мэдээлэл зүйн шинжлэх ухааны үндсийг эзэмшүүлэх;
- 6.1.4. Бүрэн дунд боловсролын агуулга нь бие бялдраа хөгжүүлж, эрүүл аж төрөх ёсыг сахиx, гэр бүлийн болон амьдрал ахуйгаа хөтлөх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах арга барилд сургах, эх оронч, хууль ёсыг дээдлэх үзэл төлөвшүүлэх.
- 4.1. Бага боловсролын агуулга нь хүрээлэн буй орчны үзэгдэл, юмсын талаар зохих шатны мэдлэг эзэмшүүлэх;

Байгаль орчныг хамгаалах тухай хууль

- 54.2 2. Экологийн боловсрол, хүмүүжил олгох, байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх ажилд төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлнэ
- 14.6 Засгийн газрын бүрэн эрх нь иргэдэд экологийн боловсрол, хүмүүжил олгох ажил багтана.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010 оны 48-р тогтоол

- Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал нь "Байгаль орчны тэнцвэрийг хадгалж, усны нөөцийг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх, биологийн олон янз байдлын хомслолоос сэргийлэх, орчны бохирдол, байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах нь хүний эрүүл оршин амьдрах, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах үндэс мөн".

ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2020 оны 24-р тогтоол

- Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

Төслийн үр нөлөөтэй байдал

Төслийн үр нөлөөтэй байдал нь төслийн хүрээнд бий болсон эерэг болон сөрөг, төслийн хүрээнд бий болгохоор зорьсон шууд болон дам нөлөөг илэрхийлдэг. ТХБ II төсөл үр нөлөөний шалгуур үзүүлэлтдээ хүрсэн байна. Өөрөөр хэлбэл, ТХБ II төсөл нь Тогтвортой хөгжлийн боловсролоор дамжуулан Монгол Улсын иргэдэд байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хариуцлагатай, тэгш хүртээмжтэй, тогтвортой ирээдүйг бий болгоход хувь нэмрээ оруулжээ.

	Биелэлт	Тайлбар
Төслийн үр нөлөөний шалгуур үзүүлэлт:		
1. Тогтвортой хөгжлийн боловсролоор дамжуулан Монгол Улсын иргэдэд байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хариуцлагатай, тэгш хүртээмжтэй, тогтвортой ирээдүйг бий болгохыг дэмжих	Биелэсэн	Төслийн хүрээнд тавьсан үр дүнгийн индикаторуудад гарсан эерэг өөрчлөлт болон үр нөлөөний үзүүлэлтийн биелэлтийг авч үзвэл төсөл нь МУ-ын иргэдэд байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хариуцлагатай, тэгш хүртээмжтэй, тогтвортой ирээдүйг бий болгоход хувь нэмрээ оруулж чадсан байна.
Дэд зорилтууд:		
1. Сурагч, багш, сургагч багш, сургуулийн менежмент, орон нутгийн удирдах ажилтнуудын ТХБ-ын талаарх ойлголт мэдлэг нэмэгдэнэ.	Биелэсэн	Хүснэгт 12-т харуулсанчлан төслийн хүрээнд сонгогдсон суурь үзүүлэлтүүд буюу эерэг өөрчлөлт гарсан буюу микро түвшний оролцогч талуудын ТХБ-ын талаарх мэдлэг, ойлголт нэмэгдсэн.
2. ТХБ-ын чиглэлээр ашиглах нөөц материалууд бэлэн болсон байна	Биелэсэн	ТХБ-ын өмнө дурдсан ТХБ 2030-ийн 8 сэдвээр 3 түвшний зорилтот бүлгийн хэрэгцээнд нийцүүлэн 24 сургалтын модул боловсруулж, ТЗЗҮБ ба ТЗЗОНБ-ийн гишүүн байгууллагууд бие биедээ харилцах сургалт зохион байгуулах замаар суралцах үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан.

ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын боловсролын салбарын бодлого боловсруулах үндэсний түвшний болон орон нутгийн удирдлага, сургууль, багш, болоод бусад оролцогчдын түвшинд ТХБ-ын ойлголт, үйл ажиллагааг дэмжих, ТХБ-ыг дэмжин хөгжүүлэх чадавхийг бэхжүүлэх зорилгоор Тогтвортой хөгжлийн боловсрол (ТХБ) төслийн 2 дахь үе шатыг 2020 оноос эхлэн БШУЯ ба БОАЖЯ-ны манлайлал дор Швецарийн Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр хэрэгжүүлж байна. Төслийн хэрэгжих хугацааг 2023 оны 06 дугаар сарын 30 хүртэл 1 жилийн хугацаатайгаар сунгасан болно.

Монгол улс дахь Швейцарын хамтын ажиллагааны газар болон БСШУСЯ-ны хооронд байгуулсан 2020 оны 81064206 тоот гэрээ, БСШУС-ын сайдын “Төслийн хэрэгжилтийн тухай” 2020 оны А/168 тоот тушаалын дагуу төслийн үндэсний түшиц байгууллагаар Боловсролын судлалын үндэсний хүрээлэн ажиллаж байна. Төслийн орон нутгийн хэрэгжүүлэгч байгууллагаар Байгаль орчны мэдээлэл сургалтын төв (БОМСТ) ТББ сонгогдон ажиллаж байна.

Уг төслийн үр дүнд бүх нийтийн тогтвортой хөгжлийн боловсролоор дамжуулан Монгол Улсад орон нутгийн тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн ТХ/НХ-ийн хэрэгцээнд суурилсан, сургууль төвтэй үндэсний хэмжээний институтчилалын бүтэц, зохицуулалт бүрдэх ба дараах 3 гол үр дүнг чухалчилж байна. Үүнд:

ТХБ-ын чиглэлээр сургалтуудыг үе шаттай зохион байгуулснаар оролцогч талуудын тогтвортой хөгжлийн боловсрол (ТХБ)-ыг хэрэгжүүлэх мэдлэг гүнзгийрч, чадавх бүрдсэн байна.

ТХБ-ыг хэрэгжүүлэх сургалтын хэрэглэгдэхүүн, арга аргачлалыг суралцагч, багш нар болон бусад төслийн үр шим хүртэгсдэд хэвлэмэл болон цахим хэлбэрээр боловсруулж хүргүүлсэн байна.

ТХБ-ын жишиг сургуулиудыг сонгон ТХБ-ыг интеграцчилах үр дүнтэй арга, аргачлалыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна.

2020 онд Тогтвортой хөгжлийн боловсрол-II төслийн баримт бичигт заагдсан төслийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийн суурь түвшинг тогтоох, баримтжуулах, мэдээлэл цуглуулж сан бүрдүүлэх, дүн шинжилгээ хийх, нөхцөл байдлыг тодорхойлох зорилготой суурь судалгааг зохион байгуулсан бөгөөд 2023 оэд төслийн хэрэгжилтийн төгсгөлийн судалгааг зохион байгуулах юм. Энэхүү ажлын даалгаврын дагуу төслийн төгсгөлийн судалгааг зохион байгуулах зөвлөх байгууллагыг төслөөс сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажиллах юм.

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захиалгаар Мэргэжлийн социологчдын холбоо нь Тогтвортой хөгжлийн боловсрол II төслийн Эцсийн үнэлгээг 2023 оны 1 дүгээр сараас 4 дүгээр сарын хооронд хэрэгжүүлэв.

I. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ХҮРЭЭ


Эцсийн үнэлгээний зорилго нь төслөөс төлөвлөж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хүрээнд төслийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт болоод төслийн хэрэгжилтийн нийц, үр өгөөж, үр нөлөөг тодорхойлоход оршино.

II. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

2.1. Эцсийн үнэлгээний дизайн

Тогтвортой хөгжлийн боловсрол II төслийн үр дүнтэй байдал болон төслийн хэрэгжилт, үр нөлөөг үнэлэхдээ Суурь судалгааны арга зүйд үндэслэн ижил аргачлал ашиглав. Ингэснээр төслийн үр дүнд гарсан өөрчлөлтүүдийг хэмжих, харьцуулалт хийх боломжтой болдог.

Зураг 1. Эцсийн үнэлгээний дизайн



Энд, A_1 нь зорилтот бүлгийн суурь судалгааны үр дүн юм; A_2 нь зорилтот бүлгийг хамруулсан 2023 онд хийж буй эцсийн шатны судалгааны үр дүн юм. X нь 2023 оны төслийн үр дүнг илэрхийлнэ. Тиймээс хөндлөнгийн оролцооны эцсийн үр нөлөөг X -ээр хэмжинэ.

Хяналт, үнэлгээ: Төслийн суурь судалгаа нь төслийн цаашдын хяналт, үнэлгээний судалгаатай харьцуулагдахуйц байна. Иймд суурь судалгаанд мониторинг (дунд шатны) / болон эцсийн шатны үнэлгээнд ашиглахад төслийн үр дүн хэмжихүйц арга зүйг баримтална.

Байршил: Талбаруудаас ирсэн судалгааны үр дүн, мэдээлэл нь харьцуулагдахуйц байх хэрэгтэй. Иймээс түүвэрлэлт нь тухайн төслийн үр шим хүртэгчдийг хангалттай хамруулах, статистикийн хувьд төлөөлөх чадвартай байна.

Хугацаа: Судалгааны үр дүн, голлох үзүүлэлтүүд нь цаг хугацааны хувьд харьцуулагдахуйц, дахин давтагдахуйц байна. Цаг хугацааны давтамжтай загвар нь ижил хувьсагч дээр хийсэн олон цуврал ажиглалтыг харьцуулж, цаг хугацааны явцад дараалан явуулахад дөхөм болно гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Мэдээлэл цуглуулах ажлыг нэг аргачлалын дагуу зорилтот талбарт нэгэн зэрэг зохион байгуулна.

Төслийн эцсийн үнэлгээнд гадна Эдийн засаг, хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын үнэлгээний аргачлалыг ашигласан.

2.2. Мэдээлэл цуглуулалтын арга зүй, хэрэглэгдэхүүний хүрээ

Тоон болон чанарын мэдээлэл цуглуулалтын аргыг аль алиныг ашиглав. Тэдгээрт асуумж, фокус бүлгийн ярилцлага, ганцаарчилсан ярилцлага, баримт бичгийн шинжилгээ, хоёрдогч статистик мэдээллийн шинжилгээ, ажиглалтын аргууд багтана.

Судалгааны зорилтот бүлгийг макро, мезо, микро түвшин болгож ангилсан. Хүснэгт 6-т мэдээлэл цуглуулалтын аргыг зорилтот бүлэг болон судалгааны агуулгын хамт харуулав.

Хүснэгт 1. Судалгааны мэдээлэл цуглуулалтын аргууд

	Судалгааны арга	Зорилт	Баримт бичгийн шинжилгээнд ашигласан материал
1	Баримт бичгийн судалгаа	Холбогдох бодлогын баримт бичиг, мэдээлэлд дүн шинжилгээ хийх	Төслөөс боловсруулсан сургалтын материал, эмхэтгэл, гарын авлага, мэдээлэл сурталчилгааны материалууд, тайлангууд гм
2	Ганцаарчилсан ярилцлага	ТЗЗҮБ, ТЗЗОНБ, ЕБС-ийн удирдлагуудаас судалгаа авах	ТХБ-ын өнөөгийн байдал, ололт дутагдал, анхаарах зүйлс, цаашдын төлөвлөгөө (lessons learnt)
3	Бүлгийн ярилцлага	Сурагч, эцэг эхчүүд, ТЗЗҮБ-ийн төлөөллөөс судалгаа авах	ТХБ-ын талаарх олон нийтийн ойлголт, үзэл баримтлал, үнэт зүйлс
4	Асуумж судалгаа	Сурагч, ЕБС-ийн VIII-XII ангийн сурагчдаас судалгаа авах	ТХБ-ын талаарх мэдээллийн эх сурвалж, ойлголт, мэдлэг, хандлага, орон нутгийн онцлог, асуудал, шийдэл, сорилтууд
5	Кэйс судалгаа	Төслийн сайн туршлагыг нэгтгэн харуулах	ТХБ-ын төлөөх туршилт зарим сургуулийн сайн туршлагыг кэйс хэлбэрээр нэгтгэх
6	Корреляцийн шинжилгээ	Үр дүнгийн хамаарлын өөрчлөлтүүдийг илрүүлэх	Загвар 30 сургуулийн СБААХ-ын өөрийн үнэлгээний Excel дата

Ганцаарчилсан ярилцлага болон ФБЯ ойролцоогоор 90-120 минут үргэлжилсэн.

2.3. Түүврийн дизайн, аргачлал

Эцсийн судалгааны түүврийн арга зүй нь төслийн Суурь судалгааны түүврийн арга зүйтэй ижил байхаар төлөвлөсөн ба тайлангийн дараах хэсэгт тоон түүврийн хэмжээ болон чанарын ярилцлагын тоо, респондентуудын мэдээллийг дэлгэрэнгүй өгүүлэв.

2.3.1. Тоон судалгааны түүврийн хэмжээ

Төслийн хүрээнд гурван түвшний дараах оролцогч талуудтай бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагыг зохион байгуулав.

Хүснэгт 2. Макро, мезо, микро түвшний оролцогч талууд

	Оролцогч талууд
Үндэсний түвшинд	ТЗЗҮБ-ийн төлөөлөл (БОАЖЯ, БШУЯ, БСҮХ, БЕГ, БҮТ, МУБИС, МХЕГ, ЦУНБХТ гм)
Орон нутгийн түвшинд	Төслийн зорилтот аймаг, дүүргийн ТЗЗОНБ-ийн төлөөлөл
Нэгж, байгууллагын түвшинд	- Зорилтот 30 сургуулийн удирдлага, багш, сурагчид, эцэг эхийн төлөөлөл, оролцогч тал - Хяналтын 6 сургуулийн удирдлага, багш, сурагчид, эцэг эхийн төлөөлөл, оролцогч тал

Төслийн хэрэгжилтэд хамрагдаагүй буюу хяналтын сургуулийн хувьд БЗД-ээс 133-р ахлах сургууль, Чингэлтэй дүүргээс 23-р сургууль, Булган аймгийн төвөөс, Архангай, Ховд, Хэнтий аймгийн сумдаас

тус тус сонгоно. Нийтдээ төслийн суурь судалгаанд сонгогдсон нийслэлийн 2 дүүрэг, 6 аймгийн 36 сургуулийн багш, сурагч, эцэг эхчүүдийг хамруулсан.

Хүснэгт 3. Төслийн зорилтот сургууль болон хяналтын сургууль

	Төслийн сургууль	Төслийн бус/хяналтын сургууль	Нийт
УБ хот	4	2	6
Аймаг, сум	26	4	30
Нийт	30	6	36

III.

Судалгаа хийх талбараас Асуумж судалгааны мэдээллийг 1,709 сурагч, 546 багш, 1,178 эцэг эхчүүдээс цахим хэлбэрээр авна. Санал асуулгын судалгаанд хамрагдах багш, сурагч, эцэг эхчүүдийн тоо хэмжээг тухайн орон нутгийн хүн амын тоо хэмжээнд тулгуурлан, хувь тэнцүүлсэн түүвэрлэлтийн аргыг ашиглаж түүврийн хэмжээг тогтоосон. Судалгааны түүврийн тоо хэмжээг Хүснэгт 10-аас үзнэ үү.

Хүснэгт 4. Тоон судалгааны түүврийн тоо хэмжээ

Байршил	Зорилтот сургууль			Хяналтын сургууль		
	Сурагч	Багш	Эцэг эх	Сурагч	Багш	Эцэг эх
УБ хот	193	59	193	109	10	64
Аймаг, сум	1,311	466	826	96	21	95
Нийт	1,504	515	1,019	205	31	159

ТЗЗҮБ ба ТЗЗОНБ-ийн гишүүд болон сургуулийн удирдлагатай нийт 30 ганцаарчилсан ярилцлагыг зохион байгуулав. Мөн эцэг эх, сурагчидтай 20 бүлгийн ярилцлагыг хийв. Чанарын судалгааны түүвэрлэлтийн тоо хэмжээг Хүснэгт 6-аас авна уу.

Хүснэгт 5. Судалгааны түүврийн хэмжээ

Аймаг, хот	Сум, дүүрэг	Сургууль	Сурагчдын судалгаа			Багш нарын судалгаа			Эцэг эхчүүдийн судалгаа		
			N	%	n	N	%	n	N	%	n
Улаанбаатар	Баянгол дүүрэг	Эрдмийн өргөө	447	3.68	61	53	3.11	16	368	3.63	40
		Шинэ эхлэл	400	3.29	51	15	0.88	5	350	3.45	37
		ЕБС-ын 28	300	2.47	45	10	0.59	8	350	3.45	40
	Баянзүрх дүүрэг	133-р ахлах сургууль	420	3.45	64	12	0.70	7	400	3.94	40
	Сонгинохайрхан дүүрэг	122-р ахлах сургууль	445	3.66	64	76	4.46	23	341	3.36	36
	Чингэлтэй дүүрэг	ЕБС-ын 23	800	6.58	109	32	1.88	10	350	3.45	70
Архангай	Аймгийн төв	ЕБ-ын 2-р ахлах сургууль	482	3.96	64	81	4.76	23	311	3.07	35
		ЕБ-ын 3-р ахлах сургууль	456	3.75	53	68	3.99	28	316	3.12	35
	Батцэнгэл сум	ЕБ-ын ахлах сургууль	148	1.22	17	32	1.88	11	225	2.22	23
	Тариат сум	ЕБ-ын ахлах сургууль	281	2.31	36	42	2.47	13	263	2.59	30
	Өндөр-Улаан	ЕБ-ын ахлах сургууль	200	1.64	26	15	0.88	4	250	2.46	35
Булган	Аймгийн төв	Эрдмийн өргөө цогцолбор сургууль	426	3.50	51	78	4.58	21	306	3.02	30
	Хишиг-Өндөр	ЕБ-ын ахлах сургууль	178	1.46	18	35	2.06	11	239	2.36	25
	Могод	ЕБ-ын дунд сургууль	53	0.44	28	21	1.23	6	186	1.83	20
	Хялганат	ЕБ-ын ахлах сургууль	173	1.42	26	37	2.17	14	238	2.35	24

Аймаг, хот	Сум, дүүрэг	Сургууль	Сурагчдын судалгаа			Багш нарын судалгаа			Эцэг эхчүүдийн судалгаа								
			N	%	n	N	%	n	N	%	n						
	Аймгийн төв	ЕБ-ын ахлах сургууль	200	1.64	24	15	0.88	5	250	2.46	27						
Орхон	Аймгийн төв	ЕБ-ын 4-р ахлах сургууль	725	5.96	90	129	7.57	16	350	3.45	48						
		ЕБ-ын 5-р ахлах сургууль	581	4.78	71	89	5.23	37	337	3.32	35						
		ЕБ-ын 14-р ахлах сургууль	851	7.00	102	102	5.99	25	340	3.35	35						
		ЕБ-ын 15-р ахлах сургууль	235	1.93	30	53	3.11	39	299	2.95	30						
Хэнтий	Аймгийн төв	Тэмүүжин цогцолбор сургууль	648	5.33	93	78	4.58	21	328	3.23	35						
		Хан-Хэнтий цогцолбор сургууль	226	1.86	53	44	2.58	15	255	2.51	35						
	Дадал	ЕБ-ын ахлах сургууль	169	1.39	18	33	1.94	7	242	2.39	37						
	Галшар	ЕБ-ын дунд сургууль	29	0.24	21	13	0.76	7	119	1.17	17						
	Баян-Адарга	ЕБ-ын ахлах сургууль	64	0.53	18	25	1.47	13	191	1.88	23						
	Жаргалтхаан	ЕБ-ын ахлах сургууль	200	1.64	23	15	0.88	6	250	2.46	27						
Хөвсгөл	Аймгийн төв	Дэлгэрмөрөн цогцолбор сургууль	843	6.93	125	109	6.40	30	346	3.41	54						
		ЕБ-ын төрөлжсөн Авъяас сургууль	170	1.40	22	50	2.94	15	251	2.47	30						
	Рашаант	ЕБ-ын ахлах сургууль	228	1.88	44	43	2.52	12	256	2.52	30						
	Цэцэрлэг	ЕБ-ын ахлах сургууль	265	2.18	51	42	2.47	15	260	2.56	30						
	Хатгал	ЕБ-ын ахлах сургууль	168	1.38	25	40	2.35	13	251	2.47	21						
Ховд	Аймгийн төв	ЕБ-ын лаборатори 1-р сургууль	518	4.26	74	86	5.05	24	333	3.28	35						
		ЕБ-ын 2-р ахлах сургууль	335	2.76	45	60	3.52	21	284	2.80	30						
	Буянт	ЕБ-ын ахлах сургууль	127	1.04	16	29	1.70	11	209	2.06	29						
	Мөнххайрхан	ЕБ-ын ахлах сургууль	168	1.38	26	26	1.53	6	250	2.46	25						
	Манхан	ЕБ-ын ахлах сургууль	200	1.64	25	15	0.88	6	250	2.46	27						
		Нийт	12,159	100	1,709	1,703	100	546	10,144	100	1,178						
Зорилтот сургууль			Төслийн бус/хяналтын сургууль			Сурагч	n≤10%			Багш	n≤20%			Эцэг эх	n≤10%		

1.3.2. Чанарын судалгааны түүвэр

Чанарын судалгааны хүрээнд 10 ярилцлагыг үндэсний, орон нутгийн болон байгууллагын түвшний оролцогч талуудтай хийж, 20 фокус бүлгийн ярилцлагыг сургуулийн удирдлага, сурагч, эцэг эхчүүдийн төлөөлөлтэй хийнэ. Чанарын ярилцлага нь асуудлын мөн чанарыг ойлгох, нөхцөл үр дагаврын холбоосыг илрүүлэхэд шинж чанартай хийгддэг гэдгээрээ онцлог.

Хүснэгт 6. Чанарын судалгаанд хамруулах оролцогч талууд

	Оролцогч талууд	ФБЯ	Ганцаарчилсан ярилцлага	Баримт бичгийн шинжилгээ
1.	БШУЯ	n/a	1	Төслийн багц материал
2.	БОАЖЯ	n/a	1	
3.	Боловсролын ерөнхий газар	n/a	1	
4.	БМДИ	n/a	1	
5.	БҮТ	n/a	1	
6.	НТБҮТ	n/a	1	
7.	МУБИС	n/a	1	
8.	МХЕГ	n/a	1	
9.	ЦУНБХТ	n/a	1	
10.	БОМСТ	n/a	1	
11.	ТЗЗҮБ, ТЗЗОНБ	8	10	Багц материал-8
12.	Төслийн ЕБС-ийн удирдлага	n/a	12	Багц материал-30

	Оролцогч талууд	ФБЯ	Ганцаарчилсан ярилцлага	Баримт бичгийн шинжилгээ
13.	Төслийн ЕБС-ийн сурагч нар	10	n/a	
14.	Төслийн ЕБС-ийн эцэг эхчүүд	10	n/a	
	Нийт	28	30	

Төслийн хүрээнд сургуулиудаас дараах мэдээллийг цуглуулсан ба тайлангийн Хавсралт 4 болох эксэл хүснэгтээс дэлгэрэнгүйг харах боломжтой. Харин төслийн логик хүрээнд ашиглагдсан үр дүнгүүдийг Хүснэгт 11-ээс харна уу.

Хүснэгт 7.Сургуулиудаас цугларсан статистик мэдээллийн жагсаалт

№	Статистик мэдээлэл
1.	Сургуулийн сурагчдын тоо: Үүнээс 8-12 ангийн сурагчдын тоо хүйсээр
2.	Төслийн үйл ажиллагаанд хамрагдсан сурагчдын тоо:хүйсээр
3.	Сургуулийн багш нарын тоо: Үүнээс 8-12 ангийн багш нарын тоо
4.	ТХБ төслийн сургалтад хамрагдсан сургуулийн удирдлагын тоо (захирал, менежер, нийгмийн ажилтан гм)
5.	ТХБ төслийн сургалтад хамрагдсан багш нарын тоо:хүйсээр
6.	Бусад сургуулийг дадлагажуулж ажилладаг эсэх, идэвхтэй сургагчдын тоо
7.	ТЗЗОНБ-тай хамтарч хэрэгжүүлсэн сургалт, үйл ажиллагааны тоо
8.	Сургууль хооронд зохион байгуулагдсан арга хэмжээний тоо
9.	ЕБС-ийн сургалт үйл ажиллагаанд ТХБ-ын үзэл санааг тусган хэрэгжүүлэх хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо
10.	ТХБ-ыг хөгжүүлэх хүрээнд сургуулийн багш, сурагчдад чиглэн зохион байгуулсан арга хэмжээний төрөл
11.	Орон нутгийн зүгээс ТХБ-ыг дэмжин олгосон санхүүжилтийн хэмжээ
12.	Орон нутгийн бусад байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо
13.	Сурагчдын шинээр байгуулагдсан ТХБ-ын чиглэлээр ажилладаг сайн дурын клубүүдын тоо
14.	Орон нутгийн нийгэм соёл, эдийн засаг, байгаль-экологийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо
15.	ТХБ-ын чиглэлээрх сайн туршлагын тоо

IV. ҮР ДҮН

ТХБ II төслийн хэрэгжилтийг үнэлэхдээ Олон улсын эдийн засаг, хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын үнэлгээний шалгуур үзүүлэлтийг ашиглав. Эдгээрт төслийн (i) үр дүнтэй байдал, (ii) төслийн нийцтэй байдал, (iii) төслийн тогтвортой байдал, (iv) төслийн үр ашигтай байдал болон (v) төслийн үр нөлөөтэй байдал багтана. Тайлангийн эдгээр хүрээнд хамаарах үр дүнг тус бүрт нь тусгасан ба ингэхдээ суурь түвшний үр дүнг, төслийн эцсийн шатанд хийсэн үнэлгээний үр дүнтэй харьцуулсан байдлаар харуулав.

Түүвэр судалгаанд хамрагдсан бүлгүүдийн хүн ам зүйн үзүүлэлтүүд

Судалгаанд хамрагдсан нийт 1,709 сурагчдыг хүйсээр нь харвал 40.1% (685) нь эрэгтэй, 59.9% (1,024) нь эмэгтэй байна. Суралцаж буй бүлгийн хувьд судалгаанд оролцсон нийт сурагчдын 85%-ийг 9-өөс 11 дүгээр ангийн сурагчид бүрдүүлж байна.

Хүснэгт 8. Судалгаанд хамрагдсан сурагчид, хүйс болон суралцдаг түвшнээр

		Давтамж	%
Хүйс	Нийт сурагчид	1709	100.0%
	Эрэгтэй	685	40.1%
	Эмэгтэй	1024	59.9%
Суралцдаг анги	8-р анги	172	10.1%
	9-р анги	573	33.5%
	10-р анги	453	26.5%
	11-р анги	428	25.0%
	12-р анги	83	4.9%

Судалгаанд хамрагдсан нийт 1178 эцэг эхчүүдийн 86.5% (1,019)-ийг зорилтот сургуулиас үлдсэн 13.5% (159)-ийг төслийн хяналтын сургуулиас бүрдүүлж байна. Суурьшлын хувьд 22.3% нь нийлэлийн сургууль, аймгийн төвийн сургууль (41.8%), сумын төвийн сургууль (35.9%) байна. Судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн 72.2% нь ямар нэгэн байдлаар хөдөлмөр эрхэлдэг ба 27.8% нь хөдөлмөр эрхэлдэггүй байна. Судалгаанд хамрагдсан нийт эцэг эхчүүдийн 84.3% нь 31-50 насны бүлгийн хүмүүс байна. Боловсролын түвшний хувьд 58.1% нь дээд боловсролтой, 27.6% нь бүрэн дунд боловсролтой байна. Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 1.4% буюу 16 нь боловсрол эзэмшээгүй байна.

Хүснэгт 9. Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүд, насны бүлэг, хүйс, боловсролын түвшингээр

		Давтамж	%
Нийт эцэг эхчүүдийн тоо		1178	100.0%
Сургуулийн төрөл	Зорилтот сургууль	1019	86.5%
	Хяналтын сургууль	159	13.5%
Суурьшил	Нийслэл	263	22.3%
	Аймгийн төв	492	41.8%
	Сумын төв	423	35.9%
Ажил эрхэлдэг эсэх	Тийм	851	72.2%
	Үгүй	327	27.8%
Насны бүлэг	25 хүртэл	17	1.4%
	26-30	52	4.4%
	31-35	140	11.9%
	36-40	408	34.6%
	41-45	258	21.9%
	46-50	187	15.9%
	51-55	87	7.4%
	55+	29	2.5%
Хүйс	Эрэгтэй	327	27.8%

	Эмэгтэй	851	72.2%
Боловсролын түвшин	Дээд боловсролтой	684	58.1%
	Тусгай мэргэжлийн болон дипломын зэрэг	82	7.0%
	Бүрэн дунд боловсролтой	325	27.6%
	Суурь боловсролтой	71	6.0%
	Бага, боловсролгүй	16	1.4%

Судалгаанд хамрагдсан 545 багш нарыг насны хувьд авч үзвэл 25-аас 50 насны бүлэгт хамаарахаар байна. Багш нарын 80.6% нь эмэгтэй, 19.4% эрэгтэй байна. Багш нарын 65.2% бакалаврын зэрэгтэй, 32,6 % магистрын түвшний зэрэгтэй байна. Мэргэжлийн зэргийн хувьд багш нарын ойролцоогоор 2/3 нь заах болон тэргүүлэх зэрэгтэй байна. Харин зөвлөх зэргийн багш нарын эзлэх хувь 1% хүрэхгүй байна. Ажилласан жилийн хувьд багш нарын ойролцоогоор 60% нь 10-аас дээш ажлын туршлагатай байна.

Хүснэгт 10. Судалгаанд хамрагдсан багш нар, мэргэжлийн зэрэг, ажилсан туршилага болон боловсролын зэргээр

		Нийт багш нарын %	Суурьшил			Сургуулийн төрөл	
			Нийслэл	Аймгийн төв	Сумын төв	Зорилтот сургууль	Хяналтын сургууль
Нийт багш нарын тоо		546	69	320	157	515	31
Нас	25 хүртэл	6.6%	2.9%	5.9%	9.6%	7.0%	0.0%
	26-30	19.4%	27.5%	19.7%	15.3%	19.8%	12.9%
	31-35	22.9%	21.7%	21.9%	25.5%	23.1%	19.4%
	36-40	18.9%	24.6%	18.4%	17.2%	18.6%	22.6%
	41-45	15.6%	5.8%	16.9%	17.2%	15.5%	16.1%
	46-50	11.2%	5.8%	12.5%	10.8%	11.3%	9.7%
	51+	5.5%	11.6%	4.7%	4.5%	4.7%	19.4%
Хүйс	Эрэгтэй	19.4%	34.8%	17.5%	16.6%	19.2%	22.6%
	Эмэгтэй	80.6%	65.2%	82.5%	83.4%	80.8%	77.4%
Боловсролын түвшин	Дипломын дээд	2.2%	4.3%	1.9%	1.9%	2.3%	0.0%
	Бакалавр	65.2%	55.1%	65.0%	70.1%	65.6%	58.1%
	Магистр	32.6%	40.6%	33.1%	28.0%	32.0%	41.9%
	Доктор	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Мэргэжлийн зэрэг	Зэрэггүй	31.5%	24.6%	30.0%	37.6%	32.6%	12.9%
	Заах арга зүйч	33.7%	46.4%	30.3%	35.0%	33.6%	35.5%
	Тэргүүлэх	34.1%	29.0%	38.4%	27.4%	33.0%	51.6%
	Зөвлөх	0.7%	0.0%	1.3%	0.0%	0.8%	0.0%
Багшилж буй жил	3 хүртэл жил	12.8%	8.7%	10.6%	19.1%	13.0%	9.7%
	4-5 жил	13.0%	4.3%	14.7%	13.4%	13.4%	6.5%
	6-9 жил	15.6%	33.3%	14.4%	10.2%	15.9%	9.7%
	10+ жил	58.6%	53.6%	60.3%	57.3%	57.7%	74.2%

Дээрх гурван бүлэг нь төслийн микро түвшний оролцогч тал болоод үр шим хүртэгч болохын хувьд өөрсдийн мэдлэг, ойлголт болон дадал зуршилд гарсан өөрчлөлтүүдийн талаар холбогдох асуултуудад хариулсан.

4.1. Төслийн хэрэгжилтийн үр дүнтэй байдал

Төслийн хэрэгжилтийн үр дүнтэй байдлыг дараах хоёр шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэв.

1. Төслийн логик хүрээнд тусгагдсан үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт;
2. Төслийн микро, мезо болон макро түвшний оролцогч талуудын ТХБ-ын талаарх мэдлэг, ойлголт болон дадал гарсан эерэг өөрчлөлтүүд;

4.1.1. Төслийн логик хүрээнд тусгагдсан үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт

ТХБ II төслийн гурван үр дүнгийн шалгуур үзүүлэлтэд хамаарах нийт 19 үзүүлэлтийн хүрээнд зорилт тавьсан. Эдгээрийг төслийн суурь түвшний үзүүлэлттэй харьцуулахад бүх түвшинд зорилтуудын дагуу үйл ажиллагаа хийгдэж, ахиц гаргасан ба зарим үзүүлэлтүүд дээр зорилтот түвшнийг давуулан биелүүлсэн байна. Хүснэгт 11-д хийгдсэн үйл ажиллагаа болон эцсийн үнэлгээний үр дүнг дэлгэрэнгүй харуулав¹. Хүснэгт 11-т харуулсанчлан төсөл 110%-ийн үр дүнгийн гүйцэтгэлийг харуулсан байна. Өөрөөр хэлбэл, Үр дүн 1. Шалгуур үзүүлэлт болох Сурагч, багш, сургагч багш, сургуулийн удирдлага, орон нутгийн удирдлагын ТХБ-ын талаарх ойлголт мэдлэг нэмэгдэнэ гэсэн зорилт 111%-иар биелж, Үр дүн 2-ын Шалгуур үзүүлэлт болох Сургалтын хэрэглэгдэхүүн нэмэгдэнэ (хөтөлбөр, агуулга, арга зүй, үнэлгээний хуудас) (99%), Үр дүн 3-ын Шалгуур үзүүлэлт болох ТХБ-ыг нэвтрүүлэх зорилтын хүрээнд үндэсний болон орон нутгийн түвшинд өгсөн бодлогын зөвлөмж боловсруулсан байна (104%) -иар тус тус амжилттай биелсэн байна.

Хүснэгт 11. ТХБ II төслийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт

№	Үзүүлэлт	Суурь түвшин 2019 он	Зорилтот түвшин 2023/06	Хүрсэн үр дүн 2023/06	Биелэлт	Тайлбар
Үр дүн 1. Шалгуур үзүүлэлт: Сурагч, багш, сургагч багш, сургуулийн удирдлага, орон нутгийн удирдлагын ТХБ-ын талаарх ойлголт мэдлэг нэмэгдэнэ						
1.1.а	Сургагч багш, багш, агуулга боловсруулагч, үнэлгээний мэргэжилтэн, сурагчийн тоо (Эм/Эр)	26,450 (82%Эм)	33,500 (72.5%Эм)	33,592 (72.5%Эм)	100%	Төслийн үндэсний түшиц байгууллага БСҮХ-ээс зохион байгуулсан сургалтын тоо: 79 сургалтад 7,142 оролцогч хамрагджээ. Сургалтууд хамрагдсан хүмүүсийг хүйсийн хувьд авч үзвэл 24% нь эрэгтэй байсан ба зорилт 20% байх шалгуурыг хангасан байна. - ТЗЗҮБ-ийн гишүүд 29 удаа сургалтад - ТЗЗҮБ-ийн гишүүн байгууллагын 50 сургалт - ТХБ ба ногоон оффисийн соёлыг нэвтрүүлэх бүтээлч санаачилга-16 жижиг төсөл

¹ Төслийн хүрээнд эерэг өөрчлөлт гарсан үзүүлэлтийг ногооноор, тавьсан зорилтдоо хүрээгүй үзүүлэлтүүдийг шараар тодруулав.

						- Байгууллага бүр ТХБ-ыг үйл ажиллагаандаа интеграцчилах - ТХБ-ын төлөөх 30 сургуульд 3 удаа мониторинг ба ТЗЗОНБ-ийн гишүүдэд менторинг - Хийнгээ суралцах үйл ажиллагаа 8х3=24 модуль
1.1.b	Олон улсын, үндэсний ба орон нутгийн түвшинд зохион байгуулсан сургалт/ бага хурал/ туршлага судлах аяллын тоо	-	16	18	110%	2021 онд “ТХБ-ын төлөөх хамтын санаачлага, түншлэл” сэдэвтэй виртуал, цахим экспо, видео мэдээлэл өгөх чуулган- 100 гаруй байгууллага, 108,766 оролцогч – 5 өдөр 2022 онд “Оролцогч талуудын түншлэл, хамтын ажиллагааг эрчимжүүлэх нь” сэдэвтэй Эко орчин, түншлэл, хамтын оролцооны чуулган- ТЗЗҮБ, ТЗЗОНБ, 30 сургууль, нийт 280 төлөөлөгч 2023 онд Тогтвортой хөгжлийн боловсролын төлөөх өсвөр насныхны хамтын санаачлага, түншлэл 400 оролцогчтойгоор 2023 оны 5 дугаар сарын 24-25-нд зохион байгуулахаар төлөвлөсөн.
1.2.	Сургалтад хамрагдсан орон нутгийн удирдах ажилтны тоо (Эм/Эр)	30 (60%Эм)	360 (55%Эм)	396 (62%Эм)	110%	Төслийн хүрээнд БОМСТ нийт 30 төрлийн 211 сургалтыг 8,153 оролцогчид зориулж оржээ.
1.3.	Сургалтад хамрагдсан сургуулийн удирдлага, сургалтын менежер, нийгмийн ажилтан, сурагчид олон нийтийн төлөөллийн тоо (Эм/Эр)	-	5,500 (80% Эм)	8,153 (77.3% Эм)	148%	
1.4.	Сургалтад оролцогчдын багадаа 20% нь эрэгтэй байна	18%	25%	24%	96%	Сургалтууд хамрагдсан хүмүүсийг хүйсийн хувьд авч үзвэл 27.2% нь эрэгтэй байсан ба зорилт 20% байх шалгуурыг хангасан байна.
1.5.	Үндэсний болоод орон нутгийн түвшинд боловсруулсан бодлогын баримт бичгийн тоо	-	4	4	100%	МХЕГ-ын сургуулийн үнэлгээний хуудас ЗГ-аар батлагдсан. (2021) Ховд аймгийн ТХБ-ын төлөвлөгөө батлагдсан. (2021) ТХБ-ыг хөгжүүлэх МУ2ын Улс орны санаачлага (2022) БО-ны менежмент: Ногоон ажлын байрны стандартыг баталсан. (2023)

						2 бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулсан. (2023)
Үр дүн 1-ийн шалгуур үзүүлэлтийн биелэлт						111%
Үр дүн 2. Шалгуур үзүүлэлт: Сургалтын хэрэглэгдэхүүн нэмэгдэнэ (хөтөлбөр, агуулга, арга зүй, үнэлгээний хуудас)						
2.1.	Төслийн дунд хугацааны үнэлгээнд тулгуурлан шинэ сургалтын хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан бодлогын баримт бичгийн тоо	-	16	16	100%	ЮНЕСКО-ийн IBE-тэй хамтран сургалтын хөтөлбөрийн мэргэжилтэн бэлтгэхээр тохиролцсон байна. Баримт бичгийн боловсруулахдаа зөвлөлдөх, чадавхи бэхжүүлэх аргачлалыг ашигласан.
2.2.	Боловсруулж сайжруулсан багшийн гарын авлага, хичээлийн төлөвлөгөө, даалгаврын асуултууд, вэб контентийн тоо	0	250	245	99%	28 хэвлэмэл материал буюу ном, гарын авлага, тайлан, үнэлгээний хуудас 76 цахим бүтээгдэхүүн буюу ном, арга зүй, постер, брошур, орчуулга, лекц, сургалтын материал 56 цахим мэдээлэл: цахим сонин, интернэтийн мэдээ (Монцамэ, MNB, PEAK) 85 видео түүнд TV нэвтрүүлэг, баримтат, YouTube, ярилцлага, подкаст бэлтгэсэн байна.
2.3.	Боловсруулсан материалд жендэрийн шинжилгээ хийсэн, гишүүн байгууллагуудад PSEAN-ийн бодлогыг хэрэгжүүлсэн тоо	0	5	5	100%	ТЗҮББ-ийн гишүүн байгууллагууд Жендэр, жендэрийн тэгш байдлын талаарх ойлголт, боловсролын салбарт баримталж буй жендэрийн бодлого, төлөвлөлт 2020 онд 22 гишүүн, 29 төлөөлөл Жендэр, үе тэнгийнхний дээрэлхэлт – МУБИС 40 оюутан 2022 онд ШХА-гийн PSEAN үнэлгээ, КОЙКА-гийн PSEAN сургалт Загвар сургуулиудад зохион байгуулсан сургалт 4 сургууль, 156 сурагч, 4 сэтгэл зүйч, 2 багш Жүжигчилсэн тоглолтоор дамжуулан жендэрийн ойлголтыг түгээн дэлгэрүүлэх (2021) СБААХ-ын сургуулийн өөрийн үнэлгээний аргачлалд жендэрийн шинжилгээ хийх
2.4.	ТХБ-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн шинэ модуль/сайн туршлагын тоо	0	200	189	95%	Дэлхийн том хичээл - Соёл олон янз байдал - Жендэрийн тэгш байдал - Хүний эрхийн боловсрол - Энх тайван ба үл хүчирхийлэл ТХБ - Уур амьсгалтын өөрчлөлтийн боловсрол - Хүрээлэн буй орчны тогтвортой байдал - Хүн төрөлхтний сайн сайхан байдал - Тогтвортой хэрэгцээ ба үйлдвэрлэл 8 сэдвээр сургагч багш, багш, 11-14 насныханд зориулсан модуль боловсруулсан ба нийт 24 модуль боловсруулж www.esd.mn вебсайт дээр цахимаар байршуулжээ.

2.5.	esd.mn цахим сайт	-	1	1	100%	Вeбсайт (esd.mn)- 28,574 хандалттай Facebook page(ESDMongolia)- 9,626 LIKE-тай Youtube сувар (esdmongolia-6946)-318 дагагч, 81 видео, 10,491 хандалттай
Үр дүн 2-ын шалгуур үзүүлэлтийн биелэлт					99%	
Үр дүн 3. Шалгуур үзүүлэлт: ТХБ-ыг нэвтрүүлэх зорилтын хүрээнд үндэсний болон орон нутгийн түвшинд өгсөн бодлогын зөвлөмж боловсруулсан байна.						
3.1.	ТХБ-ыг сургуулийн менежментэд үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна	-	60	66	110%	Сургуулийн менежментэд СБААХ-ыг нэвтрүүлэх сургалтыг зохион байгуулсан. 893 хүн бүртгүүлж, 632 хүн оролцож, 445 хүн үнэмлэх авсан байна. (2022.11.23-12.13) 1 кредит бүхий 24 цагийн сургалтад вебинар (37.5%), вебээр (31.2%), бие даалтаар (31.2%) орсон ба - 260 сургуулийн 44 оролцогч үнэмлэх авсан - 36 сургуулийн удирдлага доод тал нь 3 удаа - 32 сургууль үнэлгээг туршсан байна.
3.2.	ТХБ-ын төлөөх сургуулийн тоо	0	30	30	100%	Сургууль өөрийн үнэлгээг (i) засаглал, (ii) хүний нөөцийн чадавхи хөгжил, (iii) сургалтын хөтөлбөр, багшлахуй, суралцахуй, (iv) сургууль ба сургалтын орчин, (v) түншлэл гэсэн 5 айн хүрээнд хийсэн. Өөрийн үнэлгээнд 30 сургуулиас 16,994 респондент хамрагдсан ба сургуулиудын нэгдсэн үр дүнгээс харахад 2020 онд сургуулиуд 'зохицуулах' (1.3-3.1 оноо) түвшинд байсан бол 2022 онд 'тодорхойлох' түвшин буюу (2.4-4.2 оноо) түвшинд хүрч сайжирсан байна.
3.3.	Сургуулийн хэрэгжүүлсэн төслийн тоо	25	130	160	123%	130 жижиг төслийг 600 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн
3.4.	Олон нийт сурагчдын сэтгэл ханамж	0	85%	84.7%	99.6%	СБААХ-ийн үнэлгээгээр 926 хүний 84.7% нь төслийн хэрэгжилтэд сэтгэл ханамжтайгаа илэрхийлжээ.
3.5.	Сургууль хоорондын зохион байгуулсан арга хэмжээний тоо	3	18	18	100%	Бүх сургуулиуд хамгийн багадаа нэг үйл ажиллагаанд оролцсон. - Аймгийн түвшний туршлага солилцох өдөрлөг - Сурагчид эко зусланд харилцан суралцах - ТХБ-ын төлөөх сургууль болон ТЗЗОНЫ-ийн гишүүд бусад сургууль туршлагаа хуваалцах - 'Эко сургууль'-ийн бага хурлаар 100 сургууль сайн туршлага судалсан байна.
3.6.	Менторын тоо	-	135	135	100%	30 сургуулийн мониторинг (2021.9-10 сар)

						- ТЗЗҮБ, ТЗЗОНБ-ийн 98 гишүүн 30 сургуулийн 505 оролцогчидтой ярилцлага, хэлэлцүүлэг хийсэн СБААХ-ийн хэрэгжилтэд менторинг хийсэн (2022.5-6 сар) - ТЗЗҮБ-ийн 100 гаруй гишүүд сургууль дээр 2 өдөр ажилласан. 30 сургуулийн сайн туршлага судлах (2023.4-5) мониторинг ТЗЗҮБ, ТЗЗОНБ-ийн гишүүд 30 сургууль дээр нийт 3,000 оролцогчидтой ярилцлага, хэлэлцүүлэг хийсэн.
3.7.	Оролцсон сурагчдын тоо (эр/эм)	-	25,000 (60% эм)	25,000 (60% эм)	100%	Төсөлд хамрагдсан нийт хүний тоо 66,698 ба үүний 44% буюу 26,679 нь сурагч байна.
3.8.	Сэтгэл зүйчээс зөвлөгөө авсан хүний тоо	-	10,000	9,984	99.8%	Монголын сэтгэл зүйчдийн нийгэмлэгтэй хамтран анх удаа сургуулийн сэтгэл зүйчийг бэлтгэсэн. Ингэхдээ 30 сэтгэл зүйчдийг 45 хоногийн хугацаатайгаар сургасан. Улсын төсвийн санхүүжилтэйгээр нэмэлтээр 202 сэтгэл зүйчдийг сургаж, бэлтгэсэн. Ирэх жилүүдэд 200 сэтгэл зүйч сургуулиудад ажиллаж эхлэх ба ингэснээр МУ-ын ЕБС-ийн сургуулиудын 70% нь сэтгэл зүйчтэй болсон байх тооцоо байна. Сургуулийн сэтгэл зүйчээс 9,984 хүүхэд зөвлөгөө, тусламж авсан байна. Төслийн зүгээс 30 сургуулийн сэтгэл зүйчдийн өрөө, танхимын тохижилтод дэмжлэг үзүүлсэн ба сэтгэл зүйчдийн цалин улсын төсвөөс гаргаж байна.
Үр дүнгийн шалгуур үзүүлэлт 3- ийн биелэлт					104%	
Нийт дундаж					110%	


4.1.2. Төслийн микро, мезо болон макро түвшинд гарсан өөрчлөлтүүд

Төслийн хүрээнд байгуулсан гурван түвшний оролцогч талуудын зураглалыг Зураг 2-т харуулав. Зураг 2-т харуулснаар ТЗЗҮБ-т талуудад БОАЖЯ, БШУЯ болон түүний харьяа байгууллагууд болох БСҮХ, БЕГ, БҮТ, хуучнаар МХЕГ (одоогийн Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын хэлтэс) болон МУБИС, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллөөр МОНРТ, хэрэгжүүлэгч БОМСТ-ийн төлөөллөөс бүрдсэн нийт 11 байгууллагын 22 гишүүн харьяалагдана. Тус зөвлөлийн хувьд төслийн хүрээнд бодлого, төлөвлөлт, удирдамж чиглүүлгээр хангах үндсэн чиг үүрэгтэй ажилласан.

Харин орон нутагт төслийн хэрэгжилтийг хангах чиглэлд ТЗЗОНБ ажилласан ба уг зөвлөлд орон нутгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Боловсрол шинжлэх ухааны газар, Байгаль орчны газар, Мэргэжлийн хяналтын газар, хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллагууд болон байгаль орчны бусад байгууллагууд, сургуулиудын төлөөлөл багтсан.

СБААХ-ыг хэрэгжүүлэх, ТХБ төслийн шууд үр шим хүртэгч буюу төслийн санхүүжилтээр жижиг төслүүд хэрэгжүүлэх байгууллагаар сонгогдсон сургууль буюу тэдгээрийн багш, удирдлага, сурагч, эцэг эхчүүд, олон нийт байхаар төлөвлөсөн.

Зураг 2. Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага ба микро, мезо, макро түвшний оролцогч талуудын оролцоо, хамтын ажиллагааны зураглал



Зургийн эх сурвалж: БОМСТ-ийн ТХБ II төслийн танилцуулга

А. Микро түвшинд гарсан өөрчлөлтүүд

Төслийг хэрэгжүүлэхдээ микро түвшинд сургуулийн менежментэд “Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага (СБААХ)”-ыг нэвтрүүлэх замаар сургуулийг ТХ-ын төлөөх загвар сургууль болгон хөгжүүлэхэд ТЗҮБ-ийн гишүүд хамтран ажиллах² стратеги баримталсан. СБААХ гэдгийг суралцагчдад, нийгэмд илүү үр өгөөжөө өгөхийн тулд боловсролын байгууллагыг бүхэлд өөрчлөх, тогтвортой байдлыг сургуулийн амьдралын бүхий л хүрээнд, үйл ажиллагааны салаа мөчир бүрт бий болгохыг зорих хандлага³ гэж тодорхойлжээ. Тиймээс микро түвшинд гарсан өөрчлөлтийг нэгдүгээрт, төслийн микро түвшний суурь үзүүлэлтүүдэд гарсан өөрчлөлт, хоёрдугаарт СБААХ-ыг хэрэгжүүлэх хүрээнд төлөвлөгдсөн үйл ажиллагааны биелэлтээр үнэлэв. СБААХ-ын хүрээнд үр дүнгийн логик хүрээнд тусгагдсан олон үйл ажиллагаануудыг амжилттай хэрэгжүүлсэн байна. Жишээлбэл, Дэлхийн том хичээл

² ТХБ II төслийн баримт бичиг, 2021 оны жилийн эцсийн тайлан

³ ТХБ II төслийн танилцуулга, ТХБ-ын төлөөх хамтын санаачлага, түншлэл танилцуулга, Э.Шинэцэцэг, Дэлхийн байгаль орчны боловсролын сангийн гишүүн, Байгаль орчин мэдээлэл сургалтын төвийн гүйцэтгэх захирал

агуулгыг сургалтын хөтөлбөрт интеграцчилах хүрээнд төслийн зүгээс хөтөлбөрийг орчуулж, жишиг загвар гаргаад багш нарын дунд хичээл төлөвлөлтийн аян уралдаан зарлаж, бага (30), суурь 30), ахлах (30) бүлгээс нийт 120 хичээлийг шалгаруулаад, үндэсний цахим зөвлөгөөн хийсэн. Цахим зөвлөгөөнөө 5 өдрийн турш онлайнгаар хийхдээ салбар салбараараа хуваагдаж нэг хийсэн нь төслийн хүрээнд гарсан үр дүн, туршлагаа хуваалцсан үндэсний хэмжээний маш том ажил болжээ.

Микро түвшний оролцогч талуудын мэдлэг, ойлголт, дадалд гарсан өөрчлөлтүүд

Төслийн микро түвшний суурь үзүүлэлтийн өөрчлөлтийг харвал (Хүснэгт 12 харна уу) төслийн зорилтот сургуулийн сурагчдын ТХБ-ын талаар 'сайн мэднэ' гэж хариулсан сурагчдын хувь суурь түвшин болох 10.8%-аас 30.2%, эцэг эх 26.7%-аас 39.3% болж нэмэгдсэн байна. Харин төслийн зорилтот сургуулийн сурагчдын мэдлэг ойлголт, чадвар хандлага мэдэгдэхүйц өөрчлөгдсөн гэж үзсэн хариулсан сурагчид 37.2%-аас 42.6% болж нэмэгджээ.

Харин хяналтын сургуулийн сурагчид ТХБ төслийн талаар 'сайн мэднэ' гэж хариулсан хувь суурь түвшинтэй харьцуулахад 14.7%-аас 30.2% болж нэмэгдсэн бол хяналтын сургуулийн эцэг эхчүүдэд энэ талаарх мэдлэг нэмэгдээгүй байна. Хэдий тийм боловч орон нутагт тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх санал, санаачлага гаргасан тоо баримт бага харагдах хэдий ч сурагч, багш, эцэг эхчүүдтэй хийсэн чанарын ярилцлагуудын үеэр эдгээр бүлэг гэр бүл, баг, хороо, сургуулийн түвшинд эерэг өөрчлөлтүүдийг авчрах дадлуудыг өөрсдөө суулгаж, жижиг төсөл, санаачлагуудыг хэрэгжүүлсэн байна. Энд тоогоор хэмжигдэхгүй үр дүн, нөхцөл байдлыг илрүүлэхэд ашигладаг чанарын судалгааны давуу тал харагдаж байна. Өөрөөр хэлбэл, орон нутагт тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх саналыг багш, сурагч, эцэг эхчүүд өөрсдөө санаачлаад явахгүй ч сургууль болон нэгдсэн бүлгээс гаргасан санал санаачлагыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн жишээ олон байна. Тэдгээрийн заримаас ишлэл байдлаар оруулав.

Ишлэл 1. Эцэг эхчүүдийн мэдлэг ойлголт, дадалд гарсан өөрчлөлт

"...Төсөл хэрэгжихээс өмнө ТХБ II төслийн талаар урьд нь мэдлэг мэдээлэл хомс байсан. ТХБ төслийг сургууль хэрэгжүүлж эхэлснээс хойш энэ талаар мэдээллийг хүүхдээсээ болон эцэг эхийн группээс авч эхэлсэн. Манай гэр бүл батерэйний хог хаягдлыг хэзээ ч бусад хог хаягдалтай хамт хаяхаа больсон ба ундааны сав гэх мэт хуванцар, цаасан хог хягдлуудаа ангилдаг болсон".

Эцэг эхчүүдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас

Ишлэл 2. Багш нар, суралцагчдын ТХ-ийн санаачлагыг дэмжиж ажилласан туршлага

"...Хүүхэд байрлах төвүүдийг хичээлийн байруудыг буулгаж Хөдөлмөр зусланг байгуулсан. Хэдийгээр зуслангийн зориулалтаар барьсан ч стандарт өндөр учир сургалтын төв болгож өөрчилсөн. Өнгөлгөөний ажлыг багш нар сар бүр цалингаасаа 20,000 төгрөг цуглуулаад нэг заах аргын нэгдэл 2 сая төгрөгийн санхүүжилт босгосон. Түүнчлэн 2 оны төгсөгчид нийлээд 12 хүний суудалтай суудлын автомашиныг авч өгсөн ба тус машиныг хүүхдүүдээ зуслан руу зөөхөд ашиглана."

Сургуулийн менежертэй хийсэн ярилцлагаас

Ишлэл 3. Сурагч нарын дадал зуршилд гарсан өөрчлөлт

"...Почкений усыг яаж хэмнэх вэ гээд дотор нь тоосго эсвэл коланы саванд ус дүүргээд хийчихдэг. Тэгэхлээр нэг таталтаар 5 литр ус гоождог байсан бол 2.5литр бүр 70% буурсан. Тэрийг бүх ангийн хүүхдүүдийг гэрт нь очиж туршуулж байсан. Манай хүүхдүүд тэрэнд их

идэвхтэй юм байна лээ. Почкений усаа тэг гэж байна, гараа угаахдаа, шүдээ угаахдаа ингэж эргэж байна гээд л байдаг юм”.

Эцэг эхчүүдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас

Хүснэгт 12. Микро түвшний оролцогч талуудын мэдлэг, ойлголтод гарсан өөрчлөлтүүд

Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Эцсийн үнэлгээний үр дүн
II. Микро түвшний нөхцөл байдал		
Суурь үзүүлэлт 1.1 Тогтвортой хөгжлийн боловсролын талаар сайн мэднэ гэж хариулсан зорилтот сургуулийн сурагчдын хувь	10.8	30.2%
Суурь үзүүлэлт 1.2 Тогтвортой хөгжлийн боловсролын талаар сайн мэднэ гэж хариулсан хяналтын сургуулийн сурагчдын хувь	14.7	30.2%
Суурь үзүүлэлт 1.3 Тогтвортой хөгжлийн боловсролын талаар сайн мэднэ гэж хариулсан зорилтот сургуулийн эцэг эхчүүдийн хувь	26.7	39.3
Суурь үзүүлэлт 1.4 Тогтвортой хөгжлийн боловсролын талаар сайн мэднэ гэж хариулсан хяналтын сургуулийн эцэг эхчүүдийн хувь	19.0	12.6
Суурь үзүүлэлт 2.1 Орон нутагт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх санал гаргасан зорилтот сургуулийн ЕБС-ийн багш нарын хувь	21.9	12.2
Суурь үзүүлэлт 2.2 Орон нутагт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх санал гаргасан хяналтын сургуулийн ЕБС-ийн багш нарын хувь	19.7	6.5
Суурь үзүүлэлт 2.3 Орон нутагт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх санал гаргасан зорилтот сургуулийн ЕБС-ийн эцэг эхчүүдийн хувь	13.2	11.7
Суурь үзүүлэлт 3.1 Орон нутагт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх санал гаргасан хяналтын сургуулийн ЕБС-ийн багш нарын хувь	15.4	8.2
Суурь үзүүлэлт 3.2 Орон нутагт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх санал гаргасан зорилтот сургуулийн сурагч нарын хувь	14.4	22.5
Суурь үзүүлэлт 3.3 Орон нутагт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх санал гаргасан хяналтын сургуулийн сурагч нарын хувь	12.8	21.5
Суурь үзүүлэлт 4.1 Төслийн зорилтот ЕБС-ийн сурагчдын мэдлэг ойлголт, чадвар хандлага мэдэгдэхүйц өөрчлөгдсөн гэж үзсэн хариулсан сурагчдын хувь	37.2	42.6%

Б. Мезо түвшний өнөөгийн байдал, гарсан өөрчлөлтүүд

Төслийн мезо түвшинд аймаг/дүүргийн ТХ/НХ-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар хоорондын түншлэл, хамтын ажиллагааг хангахын тулд орон нутгийн ТЗЗОНБ-ийг байгуулан, Ногоон оффис-соёл ба ногоон худалдан авалтын арга зүйг ашиглан хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх замаар ТХБ-ын арга хандлага, зан үйл, соёлыг төлөвшүүлэх, нийтэд түгээн дэлгэрүүлэх стратегийг баримталсан⁴. Энэ хүрээнд дараах үйл ажиллагаануудыг төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

Ишлэл 4. Төслийн хүрээнд орон нутагт хэрэгжсэн хамтын ажиллагааны туршлага

“...ТЗЗОНБ-ийн үүрэг нь төслийг хэрэгжүүлэхэд орон нутагт, аймгийн нэгдсэн удирдлага удирдах чиглэл, зөвлөмж өгч ажиллах. Энэ хүрээнд бид орон нутагтаа холбогдох оролцогч талуудын хамтын ажиллагааг хангаж, уялдаа холбоотой ажиллаж тодорхой үр дүнтэй ажлуудыг гүйцэтгэж чадсан гэж харж байна.”

ТЗЗОНБ-тай хийсэн ярилцлагаас

⁴ ТХБ II төслийн баримт бичиг, 2021 оны жилийн эцсийн тайлан

Төслийн мезо түвшний өөрчлөлтийг хэмжих хоёр үзүүлэлт дээр гарсан өөрчлөлтийг Хүснэгт 13-т харуулав. Юуны өмнө ТХБ II төслийн үйл ажиллагаа “сайн хэрэгждэг” гэдгийг төслийн хүрээнд суурь судалгааны аргачлалтай ижил буюу төслийг хэрэгжүүлэгч сургуулийн удирдлагын төслийн хүрээнд хэрэгжилтэд өгсөн онооны дунджаар тооцов. Эдгээрт төслийн хүрээнд сургууль дээр хэрэгжсэн үйл ажиллагаа болоод төслийн үзэл баримтлал сургуулийн бодлого, стратегийн баримт бичигт хэр тусгагдсан байдлаар үнэлэв. Сургуулиуд дээр ТХБ II төслийг хэрэгжүүлэхдээ орон нутгийн Засаг даргын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах, сургуулийн бодлого, стратегид тусгах, багш нарын албан тушаалын тодорхойлолтод тусгах зэргээр төслийн хэрэгжилтийг хангасан байна.

Төслийн мезо түвшинд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа сургуулиудын нөөц бололцоо, чадавхи, манлайлал зэргээс шалтгаалж харилцан адилгүй үр дүн гарсан байна. Төслийг амжилттай хэрэгжихэд хамгийн эергээр нөлөөлсөн хүчин зүйлд удирдлагын манлайлал, санаачлага орж байгаа бол эсрэгээрээ зарим сургуулийн төслийн амжилтад дараах зүйлс сөргөөр нөлөөлсөн байна.

- Сургуулийн удирдлагын тогтворгүй байдал;
- Сургуулийн удирдлагын манлайлал сул, ТХБ-ын талаарх ойлголт мэдлэг сул байх;
- Хамтын ажиллагаа сул байх;
- Санаачлага дутмаг байх.

Хүснэгт 13. Мезо түвшинд гарсан өөрчлөлтүүд

Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Эцсийн үнэлгээний үр дүн
II. Мезо түвшний үйл ажиллагааны нөхцөл байдал		
Суурь үзүүлэлт 5.1 ТХБ II төслийн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үйл ажиллагаа нь сайн хэрэгждэг зорилтот сургуулийн хувь	66.1	87.9%
Суурь үзүүлэлт 6.1 ТХБ II төслийн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үйл ажиллагаа нь сайн хэрэгждэг сургуулийн байгууллагын эзлэх хувь	64.3	100%

Макро түвшний өнөөгийн байдал, гарсан өөрчлөлтүүд

Макро түвшинд ТХ/НХ-ийн Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар хоорондын түншлэл, хамтын ажиллагааг хангахын тулд ТЗЗҮБ-ийг Байгаль орчин, Боловсролын салбарын түшиц байгууллага дээр байгуулан, салбар бүрийн хүний нөөцийн чадавхийг Тогтвортой хөгжил, Тогтвортой хөгжлийн боловсрол, Ногоон оффис ба ногоон худалдан авалтын арга зүй, соёлыг ашиглан дээшлүүлэх замаар ТХБ-ын арга хандлага, зан үйл, соёлыг төлөвшүүлэх, нийтэд түгээн дэлгэрүүлэх стратегийг баримталж⁵, төлөвлөсөн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Макро түвшинд хийгдсэн ажлууд болон хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, төслүүдийн үр дүнтэй байдлыг үнэлэхдээ ТЗЗҮБ-ийн 10 байгууллагын төлөөллүүдтэй гүнзгийрүүлсэн ярилцлага зохион байгуулж төслийн үр дүнтэй байдлыг үнэлүүлсэн. Ингэхэд төслийн макро түвшний суурь үзүүлэлт буюу ТЗЗҮБ-ийн үйл ажиллагааны өөрийн үнэлгээний хувь 84.6%-аас 100% болж нэмэгдсэн байна.

Хүснэгт 14. Макро түвшний суурь үзүүлэлтэд гарсан өөрчлөлт

	Суурь түвшин	Эцсийн үнэлгээний үр дүн
II. Макро түвшний үйл ажиллагааны нөхцөл байдал		
Суурь үзүүлэлт 7.1 ТХБ II төслийн ТЗЗҮБ-ийн үйл ажиллагааны хэрэгжилтийн өөрийн үнэлгээний хувь	84.6	100%

⁵ ТХБ II төслийн баримт бичиг, 2021 оны жилийн эцсийн тайлан

Макро түвшний чадавхи бэхжих хүрээнд хийгдсэн ажил, гарсан үр дүнгүүд

Үндэсний макро түвшин дэх ТЗЗҮБ-ийн чадавх бэхжиж орон нутгийн түвшинд үйл ажиллагаа явуулж буй ТЗЗОНБ-уудад зөвлөн тусалснаар тэдгээр багууд нь цаашдаа сургуулиудад зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулсан байна. ТЗЗҮБ нь сургуулиудад шууд зөвлөн туслах үйл ажиллагаа явуулж, практикт гарч буй асуудал бэрхшээл, орон нутгийн хамааралтай сэдвийн талаарх ойлголтоо нэмэгдүүлж үүнийгээ агуулга (хөтөлбөр, багшийн мэргэжил дээшлүүлэх, сургуулийн хяналт, үнэлгээ, насан туршийн боловсрол болон олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх) боловсруулахад ашигласан байна. Төслийн гол стратеги үндэсний хэмжээний байгууллагуудын ТХБ-ын талаарх чадавхийг бэхжүүлж, үндэсний хэмжээний институтчиллын бүтэц, зохицуулалт, хэрэгжүүлэлтийн арга механизмыг бүрдүүлэхийг зорьж, ингэснээрээ төслийн хэрэгжилтийн дараа ч уг үйл ажиллагаа үргэлжлэн явагдах боломжийг бүрдүүлсэн байна.

БШУЯ-ны харьяа байгууллагуудад бүтцийн өөрчлөлт хийгдэж төслийн түшиц байгууллага-БСҮХ-ийн бүтэц, чиг үүрэг хэвээр үлдэж⁶. Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн (БСҮХ) хэмээн нэршил өөрчлөгдсөн. Мөн төслийн Техникийн зөвлөн зохицуулах үндэсний багийн (ТЗЗҮБ) гишүүн зарим байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орж⁷ Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газар (БЕГ)-ыг байгуулснаар БМДИ, НТБ, БҮТ, БХ-ийн зарим чиг үүргийг нэгтгэсэн байна. Энэхүү өөрчлөлтийн дагуу төслийн түшиц байгууллага-БСҮХ-ээс ТХБ-II төслийн гишүүн байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг болоод ТЗЗҮБ-ийн гишүүдтэй ажиллах гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Ингэснээр цаашид төслийн ТЗЗҮБ-ийн 11 гишүүн байгууллагын 22 гишүүн тогтвортой үйл ажиллагаагаа үргэлжилсэн байна. БЕГ 2022 онд албан тушаалын тодорхойлолт боловсруулахдаа тавигдах шаардлагад нь ТХБ-ын талаар мэдлэг ойлголттой байх гэдгийг тусгайлан бүх хүний албан тушаалын шаардлагад тусгажээ.

БОАЖЯ нь ногоон хөгжлийн бодлогыг дэмжин хэрэгжүүлэх ажлыг төслийн үйл ажиллагаатай уялдуулан, төслийн зарим зорилтот аймгуудад ТХБ-ын мэдээлэл, сургалт, сурталчилгааны төв байгуулах, олон нийтэд зориулсан мэдээллийн цахим контентыг боловсруулах, тоног төхөөрөмжөөр хангах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх зэргээр ажилласан байна. Цаашид БОАЖЯ ТХБ-ын үндэсний болоод орон нутгийн түвшний институтчилалыг бэхжүүлэх, төслийн хаалтын стратеги боловсруулах, ТХБ-ыг дэмжиж хөгжүүлэх асуудлаар УИХ болоод засгийн газрын түвшинд нөлөөллийн үйл ажиллагааг удирдан хэрэгжүүлэх амлалт аваад ажиллаж байна.

БСҮХ ТХБ-2030-ын Замын зураглалыг хэрэгжүүлэх Улс орны санаачлагын тайланг бичин ЮНЕСКО-той хамтын ажиллагаагаа бэхжүүлэн ажилласан байна.

⁶ Монгол Улсын Засгийн газрын 407 тугаар тогтоол, 2021 оны 12-р сарын 31

⁷ Монгол Улсын Засгийн газрын 407 тугаар тогтоол, 2021 оны 12-р сарын 31

4.2. Төслийн ач холбогдолтой байдал

Төслийн ач холбогдолтой байдлыг төслийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаанууд төслийн үр шим хүртэгчдийн хэрэгцээ шаардлага болон орон нутагт тулгамдаж буй асуудлууд руу хэр сайн чиглэсэн гэдгээр үнэлэв. Ингэхдээ хэрэгжсэн төслийн агуулга, зорилтыг харгалзан үнэлэхээс гадна гурван түвшний оролцогч талуудын үнэлгээний үр дүнг үндэслэв.

4.2.1. Сургуулиуд хэрэгжсэн төслүүд ТХ-ийн агуулгыг багтаасан байдал

Төслийн хэрэгжих хугацаанд төслийн зорилтот сургуулиуд дээр нийт 130 үндсэн болон дэд төслийг хэрэгжүүлсэн байна. Хэрэгжсэн төслүүдийг тогтвортой хөгжлийн тулгуур баганын хүрээнд авч үзвэл дараах сэдвүүдэд хувааж болохоор байна. Түүнчлэн эдгээр төслүүд нь Суурь судалгаа болон Эцсийн үнэлгээгээр орон нутагт хамгийн их тулгамдаж буй асуудлууд хэмээн нэрлэгдсэн асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн байгаа нь төслийн ач холбогдолтой байдлыг илтгэж байна. Үүнээс гадна сургуулиуд тухайн орон нутгийн цаг уурын байдал, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулсан төслүүдийн санаачилсан байв. жишээлбэл, Хэнтий аймгийн цөлжилт ихтэй бүс нутгийн Тэмүүжин цогцолбор сургууль сургуулийн хашаагаа зүлэгжүүлэх зорилготой төсөл хэрэгжүүлэх зорилт тавьсан байна.

Зураг 3. Жижиг төслүүдийн чиглэл, агуулга, ТХ-ийн гурван тулгуур баганаар

Эдийн засаг	Нийгэм	Байгаль орчин
- Цахилгаан, эрчим хүчээ хэмнэх - Сургууль дээр байгуулагдсан клубын түвшний үйлдвэрлэлийг дэмжих	- Өв соёлоо хадгалах, хамгаалах тухай - Хүүхдийн оролцоо, хөгжил - Эрүүл, аюулгүй сургуулийн орчинг бүрдүүлэх - Хүүхэд хамгаалал - Эрүүл амьдралын хэв маяг - Сурагчдын манлайллыг дэмжих	- Хог хаягдлын менежмент - Эко хэрэглээ, үйлдвэрлэл - Сургууль орчмын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх - Хүнсний ногоо тарих - Байгаль орчинд ээлтэй дадлыг сүүлгах - Байгаль эх дэлхийтэй танилцах - Хичээл танхимын агаарын чанарыг сайжруулах

Хүснэгт 15. Микро болон мезо түвшинд хэрэгжсэн төсөл, үйл ажиллагаанууд⁸

Аймаг/дүүрэг	Сургууль	Төслийн нэр
Архангай	Эрдэнэбулган сумын ЕБ-ын 2 дугаар сургууль	- Ногоон ирээдүй - INDEPEND STUDENT - Бүтээлч номын сан
	Эрдэнэбулган сумын ЕБ-ын 3 дугаар сургууль	- Хичээл туршилтын талбай - Эрүүл орчин хүүхдийн хөгжил - Эко хүүхэд- Эко орчин
	Батцэнгэл сумын ЕБ-ын сургууль	- Зохистой хэрэглээ-зөв дадал - Хүүхдийн ертөнц клуб

⁸ Төслүүд сургууль дээр хэрэгжихэд ТЗОНБ-ийн гишүүн буюу сургуулийн удирдлага чухал үүрэг, оролцоотой тул микро болон мезо түвшинд хэрэгжсэн төслүүд гэж үзэв.

Аймаг/дүүрэг	Сургууль	Төслийн нэр
		Урин хавар-Ногоон ертөнц
	Тариат сумын ЕБ-ын сургууль	- Бор сарлагийн хөөвөр - Экологийн боловсрол - Мэдээлэл технологи ба ёс
Булган	Эрдмийн Өргөө цогцолбор сургууль 2-р сургууль	- Эко орчин-Хүүхдийн хөгжил - Номтой нөхөрлөх хөгжлийн гараа - Эрүүл орчин-Хамтын хөгжил
	Хишиг-Өндөр сумын ЕБ-ын лаборатори сургууль	- Хөгжлийн ногоон оффис - Хөгжилтэй цаасхан - Амин дэмийг алган дээрээсээ
	Могод сумын ЕБ-ын сургууль	- ТХБ-орон нутгийн танхим - ТХБ-орон нутгийн танхим - Шинжлэн судлах чадвар ба ажиглалт туршилтын талбай
	Хялганат сумын ЕБ-ын сургууль	- Хялганат эко кемп - Хялганат эко кемп тохижилт сургалтын хөтөлбөр, - Агаар-эрүүл мэнд
Орхон	Баян-Өндөр сумын ЕБ-ын 4 дүгээр сургууль	- Өв уламжлал-түүх соёлын өргөө - Book café - Монгол хүүхэд-миний соёл, - Хүүхдийн оролцоо-хүүхдийн хөгжил - Зөгийн бал сурагчийн сэтгүүл - Хэл хуур-язгуур хүрээ
	Баян-Өндөр сумын ЕБ-ын 5 дүгээр сургууль	- Агаарын чанар аюулгүй орчин, - Цэцгээр гоёсон сургууль - Агаарын чанарын боловсрол олгох
	Баян-Өндөр сумын ЕБ-ын 14 дугаар сургууль	- Хэрэгцээ хэрэглээ хэмнэлт - Эрчим хүч-бидний амьдралд - Эко орчин- интеграци хичээл, Залга-салга- хэмнэ
	Баян-Өндөр сумын ЕБ-ын 15 дүгээр сургууль	- Өвлийн хүлэмж - Өвлийн хүлэмжийн тавиур - Ногоон орчин - Байгальд ээлтэй орчин, - Хүлэмжийн дэд бүтэц
Хэнтий	Тэмүүжин цогцолбор сургууль	- Эрүүл хүнс-энх амьдрал - Эмээр биш, хоолоор анагаа - Tasty corner - Хөдөлгөөн эрүүл мэнд
	Хан-Хэнтий цогцолбор сургууль	- Ногоон Хан Хэнтий - Байгальд ээлтэй тор - Эко орчин -Эрүүл хүүхэд
	Галшар сумын ЕБ-ын сургууль	- Зан заншлын өргөө - Эсгий урлалаар хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэх төсөл
	Баян-Адарга сумын ЕБ-ын сургууль	- Цэвэр цэмцгэр бидний орчин - Бүтээлч охид - Органик бордоо -Олны хүч - Бүтээлч хүүхэд
	Дадал сумын ЕБ-ын сургууль	Ирээдүйн хөтөч

Аймаг/дүүрэг	Сургууль	Төслийн нэр
		- Хөтөч сургагч бэлтгэх - Уламжлалт тоглоом-ухаалаг хэрэглээ
Ховд	Жаргалант сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль	- Хосолсон сургалтын танхим - Хос бичигтэн-Хосолсон сургалт
	Жаргалант сумын ЕБ-ын 2 дугаар сургууль	- Ухаалаг хэрэглээ - зөв хэмнэлт - Ухаалаг хандлага – Урамтай орчин - Усны гайхамшиг
	Буянт сумын ЕБ-ын сургууль	- Урлахуйн ертөнц - Органик бордоо - Алимны төгөл
	Мөнххайрхан сумын ЕБ-ын сургууль	- Судалъя, шинжилье, суралцъя, хөгжье - Угсаатны хувцас-уламжлалт өв - Угсаатны гоёл-Уламжлалт өв
Хөвсгөл	Рашаант сумын ЕБ-ын сургууль	- Чадварлаг багш чанартай боловсрол - Оролц-оролд-оройд нь хүр - Оролцоод хөгжье
	ЕБ-ын "Авьяас" сургууль	- Ирээдүйгээ золиослохгүйгээр хамтдаа хөгжье - Авьяасын урлан - Сургуульд суурилсан хичээлийн судалгаа-хамтран хөгжье - Хуруу зайны хор хөнөөл - Өглөөний цай Эрүүл дадал хэвшлийн "Хөтөч дэвтэр" - Эко орчин
	Дэлгэрмөрөн цогцолбор сургууль	- Хөдөлмөр зуслан - Хөдөлмөр зуслан сургалтын хөтөлбөр - Зуны сургалтын сурагчдын дадлага ажлын дэвтэр - Сонирхол ур чадварыг дэмжсэн сургалт
	Цэцэрлэг сумын ЕБ-ын сургууль	- Шимт хөрс - Өргөн мэдлэг-арвин туршлага - Мини-Төгөл мод үржүүлгийн газар байгуулах
	Хатгал тосгоны ЕБ-ын сургууль	Zero Waste
Улаанбаатар	Баянгол дүүргийн Эрдмийн өргөө цогцолбор сургууль	- Хөгжлийн тулгуур - Зохистой хэрэглээ ба хогийн сав - Compost - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тохируулгат орчин бүрдүүлэх төсөл
	Баянгол дүүргийн 28 дугаар сургууль	- Хүүхэд засагладаг сургууль - Хүүхэд хамгаалагч хүүхэд - Багшаас хүүхдэдээ - Багшаас багшдаа - Хүүхэд бүр өөр өөрөөр гэрэлтдэг
	Баянгол дүүргийн Шинэ эхлэл ОУ-ын хөтөлбөртэй сургууль	- Шинэ эхлэл цахим студи - Хамтдаа хөгжье - Хүчээр биш эвээр
	Сонгино-хайрхан дүүргийн 122 дугаар сургууль	- Хүүхэд хөгжлийн инкубатор төв - Уламжлалаа өвлүүлье - Номтой нөхөрлөө

Орон нутагт тулгамдаж буй эдийн засаг, нийгэм, байгаль орчны асуудлууд

Эцэг эх болон сурагчдын үзэж буйгаар төсөл хэрэгжсэн орон аймгуудад дараах нийгэм, эдийн засаг, байгаль орчны асуудлууд түгээмэл байна. Дэлгэрэнгүй жагсаалтыг Хавсралт 2-оос харна уу.

Эдийн засгийн асуудлын хувьд бүх аймгуудад өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний өсөлт иргэдийн амьдралд хамгийн дарамт үзүүлж байна. Ковид-19 цар тахлын иргэдийн эдийн засагт үзүүлсэн сөрөг нөлөө одоог хүртэл үргэлжилсээр байна.

Харин нийгмийн асуудлуудад ажилгүйдэл, ядуурал хамгийн тулгамдсан асуудал болж байна. Үүнээс гадна эцэг эхчүүдийн хүүхдүүддээ тавих хараа, хяналт муугаас өсвөр насны хүүхдүүд ялангуяа үе тэнгийнхний дээрэлхэлтэд өртөх, шилжилтийн насны сэтгэл зүйн асуудлуудаас гарч чадахгүй байх, хорт зуршилд автах, гэмт хэрэгт өртөх зэрэг эрсдэлүүд үүсч байна. **Тиймээс төсөл хэрэгжсэн сургуулиудад сэтгэл зүйчдийг ажиллуулж эхэлсэн нь цаг үеэ олсон, ач холбогдолтой ажил болжээ.** Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүд, сурагчдын хувьд хичээлийн бус цагаар дугуйлан, секцэд хамрагдах хүсэл их байдаг боловч хичээлийн танхим, цаг, хамрагдах хүүхдийн тоо хязгаарлагдмал тул өргөн хүрээг хамарч чадахгүй байгааг онцолж байна.

Байгаль орчны асуудлуудын хувьд агаарын бохирдол хамгийн их санаа зовних асуудал болж байна. Орон нутагт уурын зуух болон гэр хороололоос гарч буй утаа нь Улаанбаатар хотын агаарын бохирдолтой харьцуулагдахуйц түвшинд хүрснийг оролцогч талууд дурдаж байна. Түүний дараагаар тоосжилт, цөлжилт, элсний нүүдэл, хуурайшилтын асуудлууд нэрлэгдэж байна. Хэдийгээр эдгээр асуудлыг шийдвэрлэх зорилгоор **ногоон байгууламжийг нэмэгдүүлэх төсөл, үйл ажиллагаа хэрэгжиж байгаа ч арчилгаа тордлогоо муу байдал, хүмүүс хайр гамгүй хандах, сүйтгэж эдгээр оролдлогыг үр дүнгүй болоход нөлөөлж байна.**

Төслийн зорилтот сургуулиуд буюу төсөл хэрэгжсэн сургуулийн эцэг эх, сурагчдыг төслийн хяналтын сургуулийн бүлгүүдтэй харьцуулахад дээр дурдсан эдийн засаг, нийгэм, байгаль орчны асуудлуудыг нэрлэхдээ түүнийг шийдвэрлэх гарцыг хэлээд зогсохгүй хувь хүн, сургууль, өрхийн түвшинд ямар байдлаар хувь нэмрээ оруулах боломжтой талаар илүү их мэдлэгтэй, туршлагатай байгаа нь харагдаж байв. Өөрөөр хэлбэл, төслийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь оролцогч талуудын мэдлэг, ойлголтод эергээр нөлөөлсөн байна. Оролцогч талууд нийгэм, эдийн засаг, байгаль орчны асуудлыг тусд нь биш цогцоор нь бие биеэсээ хамаарах байдлаар харж чаддаг болсон нь төслийн хүрээнд бий болсон томоохон үр дүнгүүдийн нэг байна.

4.2.2. Төслийн ач холбогдолтой байдалд гурван түвшний оролцогч талуудын зүгээс өгсөн үнэлгээний үр дүн

Сурагчдын 38.8% нь төслийн ач холбогдолтой байдлыг дунд зэрэг, өндөр ач холбогдолтой (26.9%), маш өндөр ач холбогдолтой (12.8%) гэж хариулжээ. Судалгаанд хамрагдсан нийт сурагчдын 78.5% нь төслийн ач холбогдолтой байдалд эерэг үнэлгээ өгсөн байна. Хүснэгт 17-г харна уу Хэдий тийм боловч сургууль дээр ТХБ II төслийн хүрээнд хэрэгжиж буй үйл ажиллагаа, төслүүдэд тодорхой бүлэг хүүхдүүд манлайлж оролцох нь нийтлэг байсан ба төслийг удирдаж, зохион байгуулалтад оролцоогүй хүүхдүүдийн хувьд төслийн ач холбогдолтой байдлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл аваагүй байх магадлалтай ба энэ нь уг үнэлгээнд нөлөө үзүүлсэн байхыг үгүйсгэхгүй.

Хүснэгт 16. Төслийн ач холбогдолтой байдал, сурагчдын үнэлгээгээр

		Суурьшил			Нийт сурагчдын %
		Улаанбаатар	Аймгийн төв	Сумын төв	
Нийт сурагчдын тоо		285	875	344	1504
Ач холбогдолтой байдал	Маш бага	7.4%	10.9%	8.1%	9.6%
	Бага	11.9%	11.2%	13.7%	11.9%
	Дунд зэрэг	39.6%	38.4%	39.0%	38.8%
	Өндөр	28.1%	27.1%	25.6%	26.9%
	Маш өндөр	13.0%	12.5%	13.7%	12.8%

Харин судалгаанд хамрагдсан багш нарын 92% нь төслийн ач холбогдолтой байдалд эерэг үнэлгээ өгсөн байна. Уг үр дүн нийслэл, аймгийн төв, сумын төвийн сургуулиас хамаарсан ялгаагүй байна. Багш нарын хувьд төслийн хүрээнд хичээлийн агуулгат ТХБ-ын үзэл баримтлалыг тусгах, хичээлийг интеграцичлах, заах арга зүйтэй холбоотой цуврал сургалтуудыг авсан нь тэдний ур чадвар, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх чухал үйл ажиллагаа байсныг ярилцлагын үеэр дурьдаж байв. Хэдий тийм ч эдгээр үйл ажиллагаа нь багш нарын ажлын ачааллыг нэмэгдүүлж байсан тул сургуулийн зүгээс эдгээр үйл ажиллагааг багш нарын ажлын байрны тодорхойлолтод оруулж өгөх байдлаар шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 17. Төслийн ач холбогдолтой байдал, багш нарын үнэлгээгээр

		Нийт багш нар	Суурьшил		
			Нийслэл	Аймгийн төв	Сумын төв
Нийт багш нар		515	59	315	141
Ач холбогдолтой байдал	Маш бага	5.0%	1.4%	5.0%	6.4%
	Бага	2.9%	0.0%	2.8%	5.1%
	Дунд зэрэг	22.1%	37.7%	22.2%	22.3%
	Өндөр	48.7%	47.8%	50.0%	41.4%
	Маш өндөр	21.2%	13.0%	20.0%	24.8%

Мезо түвшинд сургуулиудын удирдлагаар төслийн ач холбогдолтой байдлыг үнэлүүлсэн ба төслийн ач холбогдолтой байдалд 87.5% нь эерэг үнэлгээ өгсөн байна. Харин макро түвшний буюу ТЗЗҮБ-ийн гишүүдийн 97% нь төслийг ач холбогдлын хувьд 'өндөр' байсан гэж үнэлсэн.

Эдгээр оролцогч талуудын үзэж буйгаар төслийн менежмент болон арга зүй нь оролцогч талууд чадавхижихад, төслийн үр дүн олон хүнд хүрэхэд эерэгээр нөлөөлсөн гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл төслийн зөвлөлийн гишүүдээр дамжуулан 11 байгууллагын албан хаагчид ТЗЗҮБ-ийн гишүүнээрээ дамжуулж байгууллагатаа ногоон оффис санаачлагыг хэрэгжүүлж, ногоон худалдан авалтын талаар ойлголттой болж байгууллагын худалдан авалтдаа нэвтрүүлжээ.

Ишлэл 5. Төслийн ач холбогдолтой байдлын талаарх макро түвшний оролцогч талын дүгнэлт

"...Зарим төслийн хувьд зөвхөн төслийн цөөн хэдэн хүний хүрээнд төсөл хэрэгжээд, хэрэгжиж байгаа байгууллага дээр нь төсөл дуусахаар татан буугдаад явдаг. **Энэ төслийн хувьд байгууллагуудыг чадавхжуулахад тухайн байгууллагын гишүүнээр дамжуулж ТХБ-ын агуулга, арга зүй болоод салбартай холбоотой мэдээллийг хүргэхэд чухал ач холбогдолтой бүтцээр ажилласан.** Энэ хүрээнд ялангуяа БСҮХ, БҮТ, БЕГ цаашлаад яаман дээр ирээд ТХБ-ын гол үзэл санаа хөтөлбөр, үнэлгээнд яаж суусан юм? Ер нь бодлогууд яаж хэрэгжиж эхэлж байгаа юм? Ямар ямар бодлогууд яаж хэрэгжсэн юм? гээд илүү бодлогын хүрээнд Яаман дээр түлхүү анхаарч, мэдээлэл өгч, сайд дарга нарт энэ асуудлыг зайлшгүй хүргэх зарчмыг баримтлан хамтарч ажилласнаараа өндөр ач холбогдолтой байсан."

БШУЯ-тай хийсэн ярилцлагаас

4.3. Төслийн үр ашигтай байдал

Төслийн үр ашигтай байдлыг “Монгол Улсын Засгийн газар болон Швейцарын Холбооны Улсын Засгийн газар хооронд байгуулсан “Тогтвортой хөгжлийн боловсрол” төслийн II үе шатыг хэрэгжүүлэх тухай гэрээ, Төслийн баримт бичигт заасны дагуу Монгол Улсын Засгийн газар төслийн хэрэгжилтийг санхүүжүүлэх, хүний нөөц, дэд бүтцээр хангахад хувь нэмэр оруулна” гэдэг зорилгод үндэслэж үнэлэв⁹.

Монгол Улсын Засгийн газар болон БСҮХ-ийн оруулах хувь нэмрийг 2 хэсэгт ангилна¹⁰;

1. бодит мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх хувь нэмэр;
2. хүний нөөц буюу төслийн зөвлөх зохицуулах баг болон гишүүн байгууллагуудын оруулах хувь нэмэр.

Хүснэгт 18-т харуулсанчлан төсөл хэрэгжсэн хугацаанд МУЗГ болон БСҮХ-ээс 69,3 сая төгрөгийг бодит мөнгөн дүнгээр оруулахаар төлөвлөсөн бол төслийн хүрээнд оролцогч **талууд 976,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг босгож** нийт 1,046.1 сая төгрөгийн гүйцэтгэлийг хийсэн байна.


Харин бодит бус мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх хувь нэмэр 152.2 сая төгрөг байхаар төлөвлөгдсөн бол нийт **1,005.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг босгож** нийт 1,157.8 сая төгрөгийн гүйцэтгэл хийсэн байна. Эдгээрээс харвал төсөл маш өндөр үр ашигтай ажиллажээ.

Хүснэгт 18. Төслийн төлөвлөсөн болон босгосон хөрөнгө оруулалт

Төлөвлөгдсөн зардлын төрөл	Төлөвлөсөн хэмжээ	Босгосон хөрөнгө оруулалт	Нийт зарцуулсан зардал
Бодит мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх хувь нэмэр	69,3 сая төгрөг	976,8 сая төгрөг	1,046.1 сая төгрөг
Бодит бус мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх хувь нэмэр	152.2 сая төгрөг	1,005.6 сая төгрөг	1,157.8 сая төгрөг

Эндээс МУЗГ-ийн бодит болон бодит бусаар оруулсан хувь нэмрийг авч үзвэл 2020-оос 2022 оны хооронд тасралтгүй нэмэгдсэн байна. Өөрөөр хэлбэл, 26.1 сая төгрөгийн бодит бус хувь нэмрийг оруулсан бол 2021 он 71.3 сая төгрөг, 2022 онд 1,060.4 сая төгрөгийн хувь нэмрийг оруулсан байна. Харин мөнгөн дүнгээр илэрхийлэх хувь нэмэр 2020 онд 17.9 сая төгрөг, 2021 онд 35.8 сая, 2022 онд 992.4 сая төгрөгийн хувь нэмэр оруулжээ.

Зураг 4. МУЗГ-ийн оруулсан хувь нэмэр, мөнгөн дүнгээр болон бодит мөнгөн бус дүнгээр, 2020-2022 он




⁹ Оруулах хувь нэмрийг гэрээнд тусгах боловч төслийн нийт төсөвт тусгахгүй гэж төлөвлөлтийн шатанд тохиролцсон болно.

¹⁰ ТХБ II төслийн 2022 оны эхний хагас жилийн тайлан

Төслийн үр ашигтай байдлыг илтгэх дараагийн үзүүлэлт бол төслийн бүрэлдэхүүн хэсгүүд буюу гарцад чиглэсэн жигд хуваарилалт байдаг. БСҮТ-ийн хувьд төслийн үр дүн 1 буюу Үр дүн 1 буюу Зорилтот сургалтуудыг үе шаттай зохион байгуулснаар оролцогч талуудын ТХБ-ыг хэрэгжүүлэх мэдлэг гүнзгийрч, чадавх бүрдүүлэхэд чиглэсэн төсвийн гүйцэтгэл 93%, Үр дүн 2 буюу Багшид зориулсан ТХБ-ын чиглэлээрх сургалтын материал, хэрэглэгдэхүүнийг хэвлэмэл ба цахим хэлбэрээр боловсруулахад чиглэсэн төсвийн гүйцэтгэл 85%, Үр дүн 3 буюу ТХБ-ын жишиг сургуулиудыг сонгон, ТХБ-ыг интеграцчилах арга, аргачлалыг дэмжих хөгжүүлэхэд чиглэсэн төсвийн гүйцэтгэл 95%, менежментийн зардлын төсвийн гүйцэтгэл 86% нийт дунджаар 90%-ийн төсвийн гүйцэтгэлтэй ажиллажээ.

Зураг 5. Төсвийн гүйцэтгэл, үр дүнгийн зорилтоор



Төслийн зарцуулалтыг харвал нийт зарцуулсан төсвөөс 2020/2021 онд 21% буюу 624.2 сая төгрөгийг, 2021/2022 онд 40% (1,183.2 сая төгрөг), 2022/2023 онд 28% (825.4 сая төгрөг)-ийг зарцуулж 2023 оны эхний улирлын байдлаар дансны үлдэгдэл 294.4 сая төгрөгтэй байна¹¹.

Зураг 6. Төсвийн зарцуулалт, оноор



Төслийг хэрэгжүүлэгч БОМСТ нь ТХБ II төслийн хүрээнд орон нутгийн хувь нэмрийг 800 сая төгрөгөөр төлөвлөж байсан бол түүнийг 3 дахин нугалсан буюу 2.4 тэрбум болтол хөрөнгө оруулалтыг босгоход өөрсдийн хувь нэмрээ оруулжээ. Зураг 7-оос дэлгэрэнгүйг харна уу.

Зураг 7. БОМСТ-ийн менежментийн хүрээнд бий болсон хөрөнгө оруулалтууд, хувь нэмэр оруулагч талуудаар



¹¹ 2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Төслийн удирдах зөвлөлийн 6 дугаар хуралдааны илтгэлээс

БОМСТ-ийн хувьд төслийн үр дүн 1 буюу Үр дүн 1 буюу Зорилтот сургалтуудыг үе шаттай зохион байгуулснаар оролцогч талуудын ТХБ-ыг хэрэгжүүлэх мэдлэг гүнзгийрч, чадавх бүрдүүлэхэд чиглэсэн төсвийн гүйцэтгэл 100%, Үр дүн 2 буюу Багшид зориулсан ТХБ-ын чиглэлээрх сургалтын материал, хэрэглэгдэхүүнийг хэвлэмэл ба цахим хэлбэрээр боловсруулахад чиглэсэн төсвийн гүйцэтгэл 79%, Үр дүн 3 буюу ТХБ-ын жишиг сургуулиудыг сонгон, ТХБ-ыг интеграцчилах арга, аргачлалыг дэмжих хөгжүүлэхэд чиглэсэн төсвийн гүйцэтгэл 99%, менежментийн зардлын төсвийн гүйцэтгэл 95% нийт дунджаар 97%-ийн төсвийн гүйцэтгэлтэй ажилласан байна.



Төслийн үр ашигтай байдлыг илэрхийлэх сайн туршлага

... Хялганат тосгоны сургуулийн хэрэгжүүлсэн жижиг төслийн хүрээнд байгуулсан эко зусланг байгуулахад орон нутгийн төсөв болон олон нийтээс 350 сая төгрөгийн хандив, санхүүжилт босгосон нь ТХБ-2030 замын зураглалын тэргүүлэх чиглэл 5-ын түншлэл, хамтын ажиллагааны ач холбогдлыг харуулав.

...Хөдөлмөр - Хөгжил сургалтын төвийн бүтээн байгуулалтаа 2022 оны 6 сарын 01-нээс өмнө хүүхэд байрлах байраа 16 болгож, сургуулийн багш ажиллагсдын 16 ЗАН байр бүрийн доторлогоо, хаалга цонхыг хариуцаж хийгээд дотроосоо цэвэр шал, шинэ доторлогоо гаднаасаа бүгд ижил өнгөтэй байхаар будаг, өнгөлгөөг хийсэн. Энэ бүтээн байгуулалтыг үндсэн төслийн санхүүжилтээс 6,5 сая төгрөг, улсын төсвөөс 10.5 сая, эцэг эхийн хандив 2 сая, Хөвсгөл аймгийн ТЗОНБ-аас 0.5 сая, сургуулийн багш ажиллагсдын хандив хөрөнгө оруулалт 42 сая нийт 61.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар багш ажиллагсдынхаа өөрсдийн хүчээр барьж байгуулсан байна.

Мөн төгсөгчдийн хандиваар 36,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 12 хүний суудалтай автомашин авч, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 70 хүүхдийн зөөлөн эдлэлийг сургалтын төвд байрлуулжээ.



Зургийн эх сурвалж: Дэлгэрмөрөн сургуулийн тайлан

4.4. Төслийн тогтвортой байдал

Төслийн тогтвортой байдлыг төслийн хүрээнд одоогийн гарсан үр дүн төслийн хэрэгжиж дууссны дараа урт хугацаанд хадгалагдах боломжтой эсэхийг оролцогч талуудаар үнэлүүлэхийн төслийн хүрээнд хийгдсэн чанарын ярилцлагууд болон хоёрдогч мэдээлэлд үндэслэн дүгнэлт хийв. Төслийн тогтвортой байдал нь **төслийн санхүү, эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчин болон байгууллагын чадамж зэрэгт нөлөөлөх** хугацааг илэрхийлдэг. Үүнээс гадна төслийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлс, эрсдэлт хүчин зүйлсийг хамруулан үзсэн.

4.4.1. Микро түвшний тогтвортой байдал

Эцсийн үнэлгээний хүрээнд хийсэн ярилцлага болон баримт бичгийн шинжилгээний үр дүнгээс харахад нийгмийн болон байгаль орчны талын тогтвортой байдал хангагдах суурь нөхцөл бүрдсэн байна. Учир нь тайлангийн эхэнд дурдсанчлан төслийн үзэл санаа сургуулийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө, сургалтын хөтөлбөр агуулга болон багш нарын ажлын тодорхойлолтод орж өгснөөрөө төслийн тогтвортой байдал хангагдах нөхцлийг бүрдүүлжээ. Түүнээс гадна сурагч, багш нар, эцэг эхчүүдийн мэдлэг, ойлголт, хандлагад гарсан эерэг үр дүнгүүд нь төслийн үр дүн хадгалагдахад хувь нэмэр оруулахаар нь тодорхой байна.

Судалгаанд хамрагдсан сурагчдын 77.2% нь төслийн тогтвортой байдлыг 'дунд зэрэг' болон түүнээс дээш эерэгээр үнэлсэн байна. Сурагчид ТХБ II төслийн хүрээнд сурсан, мэдсэн зүйлсээ бусадтай хуваалцаж нийгэмдээ эерэг хувь нэмрийг оруулах чин хүсэлтэй байгаагаа фокус бүлгийн ярилцлагын үеэр хуваалцаж байв.

Хүснэгт 19. Төслийн тогтвортой байдал, сурагчдын үнэлгээгээр

		Суурьшил			Сургуулийн төрөл		Нийт сурагчдын %
		Улаанбаатар	Аймгийн төв	Сумын төв	Төслийн сургууль	Хяналтын сургууль	
Нийт сурагчдын тоо		394	897	418	1504	205	1709
Тогтвортой байдал	Маш бага	7.9%	9.0%	7.9%	8.6%	7.8%	8.5%
	Бага	14.5%	13.7%	15.6%	13.6%	19.5%	14.3%
	Дунд зэрэг	40.9%	38.5%	34.9%	37.8%	41.0%	38.2%
	Өндөр	28.2%	26.8%	28.2%	27.9%	23.9%	27.4%
	Маш өндөр	8.6%	12.0%	13.4%	12.1%	7.8%	11.6%

Ишлэл 6. Сурагчид ТХБ-ын үзэл баримтлалыг амьдралдаа дадал болгож, бусдад нөлөөлсөн туршлагаас

"...Миний хувьд эко клубтээ яваад сургуулийнхаа орчинд их юм сурч байгаа, тэр зүйлээ гэртээ очоод **гэр бүлийнхэнтэйгээ хамтарч ажиллаад, гэр бүлийнхэндээ танилцуулна гэдэг бол хүрээ тэлж байгаа, олонд хүртээж байгаа нь бидний нэг том ажил.** Тийм учраас гэртээ хог хаягдлаа ангилах гэж үзсэн. Жишээ нь батарей, хуруу зайгаа ангилаад, гялгар уут хэрэглэхгүй байх гэж үзсэн, эдийн засгийн хувьд хэрэгтэй, хэрэггүй залгуурууд залгаатай байдаг даа тэр зүйлийг залгахгүй байх, усаа хэмнэнэ, аяганд хийж шүдээ угаах, өдөр байгалийн гэрэл байхад ихэнх хүмүүс гэрлээ асаалттай байдаг нь эдийн засгийн хувьд ядуурал үүсэж байхад байж болзошгүй асуудал юм. **Энэ бүхнийгээ гэр бүлийнхэнтэйгээ ярилцаад шийдэж байсан. Багш нар маань бид нарт их үлгэр дуурайлал болдог.** Эхнээсээ л өөрсдөө усны савтай явдаг байсан нь бид нарт нөлөөлж бид нар ч гэсэн усны савтай явж, ус ууснаар эрүүл мэндэд ч сайн нөлөөтэй юм байна гэж ойлгосноор **манай сургуулийн ихэнх хүүхэд усны савтай явдаг болсон.**"

Хэнтий аймгийн сургуулийн сурагчидтай хийсэн ФБЯ-аас

Зорилтот сургуулиас судалгаанд хамрагдсан нийт багш нарын 91.1% төслийн тогтвортой байдлыг 'дунд зэрэг' болон түүнээс 'өндөр'-өөр үнэлжээ. Төслийн тогтвортой байдлыг багш нарын хувьд сурагчид (77.2%)-тай харьцуулахад илүү өндрөөр үнэлсэн байна. Өөрөөр хэлбэл, ТХБ II төслийн хүрээнд микро түвшинд гарсан өөрчлөлтийг урт хугацаандаа хадгалагдах нөхцөл сайн бүрдсэн гэж үзэж байна. Энэ сурагчдын хувьд төслийн тогтвортой байдлыг өөрсдийн амьдралдаа бий болгосон эерэг зуршил, нөлөөллөөр харж байгаа бол багш нарын хувьд өөрсдийн сургуулийн бодлого, стратеги болон сургалтын хөтөлбөр, өөрсдийн ажлын байрны тодорхойлолтод орсон гэдгээр илүү өргөн хүрээнд харж байна.

Хүснэгт 20. Төслийн тогтвортой байдал, багш нарын үнэлгээгээр

		Нийт багш нар	Суурьшил		
			Нийслэл	Аймгийн төв	Сумын төв
Нийт багш нар		515	59	315	141
Тогтвортой байдал	Маш бага	4.9%	1.7%	4.8%	6.4%
	Бага	4.1%	1.7%	4.4%	4.3%
	Дунд зэрэг	21.9%	28.8%	21.9%	19.1%
	Өндөр	47.6%	47.5%	50.2%	41.8%
	Маш өндөр	21.6%	20.3%	18.7%	28.4%

Ишлэл 7. ТХБ-ын тогтвортой байдалд багш нарын өгч буй үнэлгээ

"... ТХБ-ын үзэл санааг илүү тогтвортой авч явахын тулд хүүхэд, эцэг эх, багш нарын дадалд нэвтрүүлэхийг зорьсон. Хэрэгжүүлсэн төсөл санаачлагуудыг хэрэгжүүлсний дараах үр дүнгээс харахад эдгээр зорилтуудаа биелүүлж чадсан гэж харагддаг. Учир нь эцэг эхчүүд хүүхдүүдийн гаргаж буй санаачлагуудыг дэмжих, гэртээ хог хаягдлаа ангилах дадалд суралцсан. Батерэйг тусгай шилэн саванд ангилан хаях гэх мэт эцэг эхчүүд өөрсдөө санаачлагууд дэвшүүлэх болсон. Сургуулийн түвшинд төслийн тогтвортой байдлыг 4 оноогоор үнэлнэ. Учир нь төсөл дуусахад төслийн үргэлжлүүлээд аваад явах төрийн захиргааны байгууллагыг албан ёсоор томилж өгвөл төслийн үзэл санаа тасралтгүй хэрэгжиж, төслийн хүрээнд одоо гарсан үр дүнгүүд тогтвортой хадгалагдана."

Сургалтын менежертэй хийсэн ярилцлагаас

4.4.2. Төслийн мезо түвшний тогтвортой байдал

Төслийн мезо түвшин нь ТЗЗОНБ-ийн түвшний үйл ажиллагаа буюу орон нутагт төслийн оролцогч талуудын түншлэл хамтын ажиллагааг тогтвортой хангахад ТЗЗОНБ-ийн гишүүд болох ЗДТГ, Боловсрол шинжлэх ухааны газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын байцаагч, Хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллагууд, Байгаль орчны асуудал хариуцсан байгууллагууд, Сургуулийн төлөөллүүд төслийн талаар ойлголттой байх, үзэл санааг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх итгэл үнэмшил, оролцоо болон санхүүгийн хөшүүрэг чухал ч мезо түвшинд энэ урьтач нөхцөл хангагдахгүй байна. Учир нь ТХБ II төслийн хэрэгжилтийг орон нутаг зангидаж, зохицуулах чиг үүрэг бүхий Нийгмийн бодлогын газрын дарга болон ТЗЗОНБ-ийн Нарийн бичгийн дарга нар байнга солигддог төслийн үзэл баримтлалын залгамж халаа алдагдаж орон нутгийн түвшинд манлайлал, санаачлага дутагдахад хүргэж байна.

Түүнчлэн ТЗЗОНБ-ийн гишүүд нь төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлснээрээ ямар нэгэн нэмэлт урамшуулал авдаггүй байдал нь тэдний оролцоо сул байх нэг шалтгаан болж байна. Тиймээс төсөл дууссны дараа төслийн багийн гишүүд энэхүү төслийн үзэл баримтлалыг үргэлжлүүлэхийн тулд идэвх, санаачлага гаргана гэдэг нь эргэлзээтэй. Түүнээс гадна ТЗЗОНБ-ийн үйл ажиллагаа ТЗЗҮБ-ийн

боловсруулсан нэгдсэн төлөвлөгөө, санаачлага, манлайллаас шууд хамаарч байсан тул төсөл дуусахад төслийн хүрээнд мезо түвшинд хэрэгжиж байсан үйл ажиллагаа буюу жижиг төслүүд, сургалт, чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа үргэлжилэхгүй байх эрсдэлтэй.

4.4.3. Төслийн макро түвшний тогтвортой байдал

Төслийн тогтвортой байдалд ТЗЗҮБ-ийн гишүүд буюу БОАЖЯ, БШУЯ, БСҮХ, БОМСТ, БЕГ, МХЕГ, МУБИС, БҮТ, ЦУБХТ, ХМТ-ийн төлөөлөл 77.5%-ийн үнэлгээ өгсөн ба үнэлгээний бусад шалгуур үзүүлэлтүүдэд өгсөн үнэлгээтэй харьцуулахад хамгийн бага үнэлгээ өгсөн. ТЗЗҮБ-ийн гишүүд төслийн бусад оролцогч талуудаас ялгаатай нь төслийн тогтвортой байдлыг төслийн өргөн хүрээний оролцогч талуудын хамтын ажиллагаа үргэлжилж, төслийн хэрэгжилтийн хугацаанд гарч байсантай ижил санаачлагууд төсөлд хамрагдсан болон төсөлд хамрагдаагүй сургуулиуд дээр гарах талаас нь харж байна. Энэ өнцгөөс ТЗЗҮБ-ийн оролцогч талууд төслийн тогтвортой байдлыг хангахад одоогийн бодлого, эрх зүйн орчинг сайжруулах шаардлагатай гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, төслийн үзэл санаа болон төслийн ТЗЗҮБ-ийн бүтцийг идэвхитэй хангахад хууль эрх зүй, бодлогын түвшний дэмжлэг, орчин чухал нөлөөтэй. МУ-д бүх түвшний боловсролын бодлогууд, тэдгээрийн зорилтуудыг хангах чиглэлд өөрсдийн чиг үүргийн дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Хэдий тийм ч ТЗЗҮБ-ийн албан ёсны бүтэц байснаараа оролцогч байгууллагууд тогтмол чадавхи бэхжүүлэх үйл ажиллагаануудад (сургалт, туршлага судлах тойрон аялалд) хамрагдаж үйл ажиллагаагаа илүү уялдаа холбоотой, үр дүнтэй төлөвлөж хэрэгжүүлэх давуу талтай болохыг төслийн хүрээнд харьцангуй богино хугацаанд гарсан үр дүнгүүд харуулсан. Үүнд, төслийн орон нутагт хэрэгжүүлэхээр сонгогдон ажилласан БОМСТ болон БСҮХ-ийн хажууд байгуулагдсан төсөл хэрэгжүүлэх нэгжийн үүрэг, оролцоо чухал байсныг онцлох нь зүйтэй.

Жишээлбэл, МХЕГ буюу одоогийн БШУЯ-ны харьяа Эрүүл мэнд, Боловсрол, соёлын хяналтын хэлтэс БОМСТ-той хамтран Сургуулийн үнэлгээний хяналтын шинэчлэн боловсруулсан. Уг хяналтын хуудсын шинэчлэгдсэн хувилбар нь СБААХ-ын агуулга, жишээлбэл, хүний эрх, жендэрийн асуудлуудыг тусгаснаараа онцлог. Уг Тогтвортой хөгжлийн боловсролын агуулгатай 35 асуулт багтсан хяналтын хуудсыг Шадар сайдаар батлуулж одоогоор улсын ерөнхий боловсролын 859¹² сургуульд ашиглагдаж байна.

Жишээлбэл, ТЗЗҮБ-ийн гишүүд төслийн зорилтот аймаг, дүүргийн ТЗЗОНБ-ийн гишүүдэд менторын дэмжлэг үзүүлэн, нөлөөллийн үйл ажиллагаанд нь зөвлөн тусалснаар Ховд аймаг ТХБ-ын дэд хөтөлбөрийг боловсруулж, 3 жилийн хэрэгжилтэд 300 орчим сая төгрөгийн санхүүжилт босгож чадсан байна.

Төсөл дууссны дараа дээрх бүтэц татан буугдсаар дээр дурдсан шиг хэмжээний үр дүн гарах нөхцөл сулрах нь тодорхой. Тиймээс төсөл дээр хэрэгжүүлсэн туршлагыг үргэлжлүүлэх арга замыг ЗГ-ын бодлого, тогтоомж, журамд оруулсан тохиолдолд макро түвшний тогтвортой байдал хангагдах боломж үүснэ.

¹² ҮХС, 2023 оны 4 сарын 25-ны байдлаар

4.5. Төслийн нийцтэй байдал

Төслийн нийцтэй байдлыг төслийн зорилго, зорилтууд МУ-д хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дараах бодлого, хөтөлбөрийн зорилтуудтай хэр уялдаж, тэдгээрт хэрхэн хувь нэмрээ оруулсныг тойм байдлаар харуулав. Дараах жасгаалтаас харуулсанчлан ТХБ II төсөл нь МУ-ын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын зорилго, зарчим болон МУ-ын дунд болон урт хугацааны бодлогын баримт бичгийн зорилтуудтай уялдсан үйл ажиллагааг хэрэгжүүлжээ.

Тогтвортой хөгжлийн зорилт 2030

- Зорилт 4.а Хүүхэд, хөгжлийн бэрхшээл, жендерийн мэдрэмжтэй боловсролын байгууллагыг бэхжүүлэн сайжруулж, хүн бүрийг аюулгүй, хүртээмжтэй, үр дүнтэй суралцах орчноор хангах
- Зорилт 4.с 2030 он гэхэд хөгжиж буй орнууд, ялангуяа нэн буурай хөгжилтэй болон жижиг арлын хөгжиж буй улс орнуудад багш бэлтгэх сургалтын чиглэлийн олон улсын хамтын ажиллагаагаар дамжуулан дадлага туршлагатай багш нарын хангамжийг [х] хувиар нэмэгдүүлэх
- Зорилт 4.7 2030 он гэхэд тогтвортой хөгжлийн мэдлэг, тогтвортой амьдралын хэв маяг, хүний эрх, жендерийн тэгш байдал, энх тайван болон хүч үл хэрэглэх соёлыг төлөвшүүлэх, дэлхийн иргэн байх, соёлын олон янз байдал болон тогтвортой хөгжилд соёлын оруулж буй хувь нэмрийг ойлгуулах мэдүүлэх замаар тогтвортой хөгжлийг хөхүүлэх дэмжихэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг бүх суралцагчдад олгох
- Зорилт 12.8 Хаа сайгүй хүмүүс байгальтайгаа нийцсэн амьдралын хэв маяг, тогтвортой хөгжлийн талаар холбогдох мэдээлэл, мэдлэгээр хангах
- Зорилт 13.3 Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх боловсрол, ухамсарыг дээшлүүлэх, хүний нөөцийн болон байгууллагын чадавхийг сайжруулах

Боловсрол-2030 Инчоны тунхаглал

- Бидний алсын хараа бол Хөгжлийн гол хөдөлгөгч хүч (замчлагч) болж, тогтвортой хөгжлийн бусад бүх зорилтыг амжилтад хүргэх боловсролын үүрэг ролийг ухамсарлаж, боловсролоор дамжуулан амьдралыг хувирган өөрчлөх явдал юм.

Дэлхий нийтийн үйлийн хөтөлбөр-ДНҮХ (2015-2019)

- ТХБ-10 жил`-ийн ололт амжилтад тулгуурлан ДНҮХ (GAP) нь ТХБ-д тодорхой үйлүүдийг үүсгэн бий болгож, цар хүрээг нь өргөжүүлэх зорилготой." Парисын уур амьсгалын бага хурал (COP 21). COP21-ийн гол үр дүн болох

Парисын хэлэлцээр

- 11, 12 дугаар зүйл: 12 дугаар зүйл: Талууд уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол, сургалт, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, тэдний оролцоо, мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авахад, хамтран ажиллах ёстой.

Алсын хараа 2050

- Зорилго 2.1.Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ.
- Зорилго 6.Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулна.
- Зорилго 8.Үндэсний соёлоо дээдэлсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ

өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцад нэгдсэн, өрсөлдөх чадвартай, харьцангуй тэнцвэртэйгээр бүс, орон нутгийг хөгжүүлнэ.

Боловсролын тухай хууль

- 4.1. Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхитай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино.

Бага, суурь, бүрэн дунд боловсролын тухай хууль

- 6.1.2. Бүрэн дунд боловсролын агуулга нь байгаль, нийгэм, хүмүүнлэг, математик, мэдээлэл зүйн шинжлэх ухааны үндсийг эзэмшүүлэх;
- 6.1.4. Бүрэн дунд боловсролын агуулга нь бие бялдраа хөгжүүлж, эрүүл аж төрөх ёсыг сахиx, гэр бүлийн болон амьдрал ахуйгаа хөтлөх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах арга барилд сургах, эх оронч, хууль ёсыг дээдлэх үзэл төлөвшүүлэх.
- 4.1. Бага боловсролын агуулга нь хүрээлэн буй орчны үзэгдэл, юмсын талаар зохих шатны мэдлэг эзэмшүүлэх;
- 4.1.6. өөрийн болон бусдын хөдөлмөрийг хүндэтгэх, үнэнч шударга, хамтач байдлыг эрхэмлэх зэл төлөвшүүлэх;

Байгаль орчныг хамгаалах тухай хууль

- 54.2. Экологийн боловсрол, хүмүүжил олгох, байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх ажилд төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлнэ
- 14.6 Засгийн газрын бүрэн эрх нь иргэдэд экологийн боловсрол, хүмүүжил олгох ажил багтана.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010 оны 48-р тогтоол

- Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал нь "Байгаль орчны тэнцвэрийг хадгалж, усны нөөцийг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх, биологийн олон янз байдлын хомслолоос сэргийлэх, орчны бохирдол, байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах нь хүний эрүүл оршин амьдрах, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах үндэс мөн".

ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2020 оны 24-р тогтоол

- Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

Монгол Улсын Засгийн газрын "Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө 2016-2030"

- 5.1.4-т "Эко сургуулийн үйл ажиллагааг дэмжиж байгаль орчноо хамгаалах уламжлалт ёс заншил, байгальд ээлтэй амьдралын хэв маягийг хүүхэд, залууст төлөвшүүлэх"
- 5.2-т "Байгаль орчны удирдлагын MNS ISO 14000 багц стандартыг аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрүүлэхийг хөхиүлэн дэмжиж, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хэрэглээний хэмнэлттэй зөв дадлыг бий болгох"
- "Тогтвортой хөгжлийн боловсрол" үндэсний хөтөлбөр <https://www.legalinfo.mn/annex/details/8620?lawid=13595>
- 4.3. "Олон улсын Эко сургууль хөтөлбөрт хамрагдах сургуулийн өмнөх, бага, дунд боловсролын сургалтын байгууллагын тоог 2017 онд 255, 2020 онд 350, 2022 онд 450-д хүргэсэн байна.

4.6. Төслийн үр нөлөөтэй байдал

Төслийн үр нөлөөтэй байдал нь төслийн хүрээнд бий болсон эерэг болон сөрөг, төслийн хүрээнд бий болгохоор зорьсон шууд болон дам нөлөөг илэрхийлдэг¹³. Аливаа төслийн үр нөлөө гарах хугацаа тухайн төслийн цар хүрээ, хэрэгжилтээс хамааран ялгаатай байдаг. Төслийн үр нөлөөг үнэлэхдээ төслийн хүрээнд тавьсан үр нөлөөний шалгуур үзүүлэлтийн биелэлтэд оролцогч талуудын өгсөн үнэлгээний үр дүн болон баримт бичгийн шинжилгээний үр дүнг үндэслэв.

Хүснэгт 21-т харуулсанчлан ТХБ II төсөл үр нөлөөний шалгуур үзүүлэлтдээ хүрсэн байна. Өөрөөр хэлбэл, төслийн хүрээнд МУ-ын бодлого боловсруулах болоод шийдвэр гаргах үндэсний түвшин төдийгүй орон нутгийн түвшинд ТХБ-ыг тасралтгүй хөгжүүлэх чадавхийг бэхжиж, ТХБ-ыг хэрэгжүүлэх сургалтын хэрэглэгдэхүүн, арга аргачлалыг суралцагч, багш нар болон бусад төслийн үр шим хүртэгсдэд хэвлэмэл болон цахим хэлбэрээр боловсруулагдсан. Түүнчлэн төслийн зорилтот сургуулиуд ТХ-ийн үзэл санааг тусгасан жижиг төслүүд хэрэгжүүлэхээс гадна томоохон урт хугацаанд нийгэм, эдийн засаг, байгаль орчинд эерэг өөрчлөлтүүдийг авчрах бүтээн байгуулалтуудын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Хүснэгт 21. Төслийн логик хүрээнд тусгагдсан үр нөлөөний шалгуур үзүүлэлт ба биелэлт

	Биелэлт	Тайлбар
Төслийн үр нөлөөний шалгуур үзүүлэлт:		
2. Тогтвортой хөгжлийн боловсролоор дамжуулан Монгол Улсын иргэдэд байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хариуцлагатай, тэгш хүртээмжтэй, тогтвортой ирээдүйг бий болгохыг дэмжих	Биелэсэн	Төслийн хүрээнд тавьсан үр дүнгийн индикаторуудад гарсан эерэг өөрчлөлт болон үр нөлөөний үзүүлэлтийн биелэлтийг авч үзвэл төсөл нь МУ-ын иргэдэд байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хариуцлагатай, тэгш хүртээмжтэй, тогтвортой ирээдүйг бий болгоход хувь нэмрээ оруулж чадсан байна.
Дэд зорилтууд:		
3. Сурагч, багш, сургагч багш, сургуулийн менежмент, орон нутгийн удирдах ажилтнуудын ТХБ-ын талаарх ойлголт мэдлэг нэмэгдэнэ.	Биелэсэн	Хүснэгт 12-т харуулсанчлан төслийн хүрээнд сонгогдсон суурь үзүүлэлтүүд буюу эерэг өөрчлөлт гарсан буюу микро түвшний оролцогч талуудын ТХБ-ын талаарх мэдлэг, ойлголт нэмэгдсэн.
4. ТХБ-ын чиглэлээр ашиглах нөөц материалууд бэлэн болсон байна	Биелэсэн	Хүснэгт 11 харуулсанчлан ТХБ-ын өмнө дурдсан ТХБ 2030-ийн 8 сэдвээр 3 түвшний зорилтот бүлгийн хэрэгцээнд нийцүүлэн 24 сургалтын модул боловсруулж, ТЗЗҮБ ба ТЗЗОНБ-ийн гишүүн байгууллагууд бие биедээ харилцах сургалт зохион байгуулах замаар суралцах үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан.

Төслийн үр нөлөөтэй байдлын гурван түвшний оролцогч талуудаар үнэлүүлсэн. Хүснэгт 23-т харуулсанчлан судалгаанд хамрагдсан багш нарын 90.3% нь төслийн үр нөлөөтэй байдалд эерэг нөлөө үзүүлсэн буюу төсөл нь тухайн орон нутаг болоод МУ-ын нийгэм, эдийн засаг, байгаль орчинд хэрэгжүүлсэн үйл ажиллагааныхаа хүрээнд хувь нэмэр оруулсан гэж үзэж байна. Микро түвшний

¹³OECD. 2021, Applying evaluation criteria thoroughly

оролцогч талуудаас төслийн үр нөлөөтэй байдалд багш нар хамгийн өндөр оноо өгсөн байсныг онцлох нь зүйтэй.

Хүснэгт 22. Төслийн үр нөлөөтэй байдалд багш нарын өгсөн үнэлгээ

		Нийт зорилтот сургуулийн багш нарын %	Суурьшил		
			Нийслэл	Аймгийн төв	Сумын төв
Нийт зорилтот сургуулийн багш нар		515	59	315	141
Үр нөлөөтэй байдал	Маш бага	4.7%	1.7%	4.8%	5.7%
	Муу	5.0%	6.8%	4.4%	5.7%
	Дунд зэрэг	23.1%	27.1%	22.2%	23.4%
	Өндөр	44.3%	44.1%	46.7%	39.0%
	Маш сайн	22.9%	20.3%	21.9%	26.2%

Харин мезо түвшний оролцогч талууд төслийн үр нөлөөтэй байдлыг өндрөөр үнэлсэн. Учир нь төслийн үзэл санаа болон үйл ажиллагаа нь орон нутгийн ЗДТГ болон Боловсролын газар, Байгаль орчны газар, Нийгмийн бодлогын хэлтэс зэрэг оролцогч талуудын үйл ажиллагааны чиглэлтэй уялдаж байсан нь төслийг үр дүнтэй хэрэгжүүлж, орон нутгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчинд эерэг үр нөлөө авчирсан байна. Түүнчлэн төслийн үр нөлөөтэй байдлыг илэрхийлэх нэг үзүүлэлт бол төсөлд хамрагдаагүй сургуулиуд төслийн зорилтот сургуулиуд болон орон нутгийн боловсролын газар, ЗДТГ-аас төсөлд хамрагдах боломжийг судалж, туршлага судлах хүсэлтүүд ирж байснаас харж болохоор байна.

Ишлэл 8. Төслийн хүрээнд орон нутагт бий болсон үр нөлөө

“...ТХБ II төсөл нь Мөрөн сумын засаг даргийн 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн “ЭКО ХӨГЖЛИЙН БОДЛОГО” иргэдийн оролцоонд түшиглэж, байгаль орчныг хамгаалах нөөц баялгийг хамгаалах үр өгөөжтэй ашиглах, нөхөн сэргээх, орчны бохирдлыг бууруулж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилго болон ХОГГҮЙ-МӨРӨН сумын хог хаягдлын менежментийг сайжруулах зорилтын 5.1.4 Хог хаягдлыг ангиалан ялгах, олон нийтийн хандлагыг өөрчлөх зорилтуудтай уялдаж орон нутгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчинд томоохон хувь нэмэр оруулсан гэдгийг дурдах нь зүйтэй.”

Ишлэл 9. Төслийн үр нөлөөний шалгуур үзүүлэлтийн биелэлтэд ТЗЗҮБ-ийн гишүүний өгсөн үнэлгээ

